

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ  
НОМЫН САН**

# **Шинэ номын мэдээ**

**2018.04**

**№ 2**

**Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа**

**Ном зүйч У.Гэрэлтуяа**

**Электрон каталоги:  
<http://catalog.num.edu.mn>**

ГАРЧИГ

|                                                  |       |
|--------------------------------------------------|-------|
| БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                     | 1-2   |
| БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                     | 2-4   |
| ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....                    | 4-6   |
| ТЕХНИК БА ТЕНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....            | 6-7   |
| ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН АЖ АХУЙ.....                | 7-8   |
| НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                      | 8-9   |
| ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                       | 9-14  |
| ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                 | 15-19 |
| УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                    | 20-23 |
| ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....         | 24-29 |
| ШИНЖЛЭХ УХААН. ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.....         | 29-33 |
| БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ШИНЖЛЭХ УХААН..... | 33-35 |
| СЭТГҮҮЛ ЗҮЙ. НОМЫН САН СУДЛАЛ.....               | 36-37 |
| ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....                   | 37-39 |
| УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....                          | 39    |
| УРАН ЗОХИОЛ.....                                 | 40-45 |
| УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ.....                         | 45-47 |
| ШАШИН СУДЛАЛ.....                                | 47-48 |
| СЭТГЭЛ СУДЛАЛ.....                               | 49-50 |
| ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ.....                        | 50-52 |

Товчилсон үгийн тайлбар:

БУН-Байгалийн ухааны номын уншлагын танхим /306тоот/  
 НУН-Нийгмийн ухааны номын уншлагын танхим /211тоот/  
 ГНОФ-Гэрээр ном олгох фонд /109, 110тоот/  
 ГФ-Гадаад номын фонд /411тоот/  
 ЭШФ-Эрдэм шинжилгээний фонд /411тоот/  
 БС-Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505тоот/  
 ХЗС-Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205тоот/  
 ОУХНУС-Олон улсын харилцаа. Нийтийн удирдлагын  
 сургуулийн номын сан /Хич-V 304тоот/

## БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААН



ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ  
АРГА ХЭМЖЭЭ, ТЕХНОЛОГИ  
Монгол Улсын орлогч зохиолчид хамт зохиосон

**Цөлжилттэй тэмцэх арга хэмжээ, технологи** / Н.Мандах, Д.Даш, А.Хауленбек ба бус.; Ред. Ж.Цогтбаатар.- УБ.: Адмон принт, 2016.- 268х.- ISBN 978-99973-0-900-6.

Уг бүтээлд цөлжилтийн үйл явцыг танин мэдэх, судлах, мониторинг хийх хэрэгцээ шаардлага, цөлжилттэй тэмцэхэд Монгол улсад хэрэгжүүлбэл зохих ойжуулалт, ус хуримтлуулах, хөрсийг нөхөн сэргээх технологийн шийдлүүд, тэдгээрийг туршсан үр дүн болон судалгааны үр дүнгээс гарсан зарим санал, зөвлөмжийг тусгажээ. Энэхүү бүтээлийг байгаль орчны салбарт ажиллагсад, эрдэм шинжилгээний ажилтан, байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр ажиллагсад болон оюутан сурагчид хэн бүхэн гарын авлага болгон ашиглах боломжтой юм.

20.1

Ц-813

ЭШФ Т-21114

**Жамбал А. Математикч философич Жалбын Цэдэнжав:** Амьдрал үйлс, бүтээл туурвил / Ред. Ц.Урнаа.- М.: “Алекс” (ИП Поликанин А.А.), 2017.- 156х.- ISBN 978-5-9618-0079-1.



Ардын хувьсгалын эхэн үед өсөж өндийж, сурч боловсорсон Монгол улсын сэхээтнүүдийн нэг гавьяат багш Жалбын Цэдэнжавын мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан түүний амьдрал, үйлс, бүтээл туурвилын талаар эрдэм шинжилгээний болон намтарчилсан бүтээлийг та бүхэнд хүргэж байна. Ж.Цэдэнжав нь XX зууны монголын дээд боловсролын системд математикийн болон философийн сургалт боловсрол, сурталчилгаа, судалгаа, ном, сурах бичгийн орчуулгад үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

22.1г+87.3г

Ж-231

ЭШФ Т-21502-21504



**Онолын механик** / Г.Очирбат, Д.Улам-Оргих, П.Мөнхбаатар, Н.Төвжаргал; Хян. М.Отгонбаатар.- УБ.: Артсофт, 2016.- 237х.- (Монгол Улсын Их Сургууль. Физикийн тэнхим).

Энэхүү сурах бичиг нь ньютонь болон аналитик механикийн үндсийг агуулсан бөгөөд механикийн элементар зарчим, лагранжийн тэгшитгэл, бөөмсийн мөргөлдөөн, хатуу биеийн кинематик зэрэг онолын механикийн үндсэн ойлголтыг агуулсан байна. Мөн ихэнх бодого нь бодолттой, хялбар бодлого нь хариутай бичигдсэнээрээ улс болон олон улсын олимпиадад бэлтгэж байгаа сурагчид, оюутнуудад гарын авлага болохоор ач холбогдолтой болжээ.

22.21я73

О-354

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-21361-21363

Адъяасүрэн П., Жаргалсайхан Б. **Химийн лавлах:** Орос, англи, монгол / Хян. Г.Сүхдорж, Н.Сугар.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 304х.- ISBN 978-99978-0-507-2.



Химийн шинжлэх ухааны бүхий л салбар болох органик бус хими, органик хими, биохими, аналитик хими, физик ба коллоид хими, нефтийн хими, полимер хими, геохимийн өргөн хэрэглэгддэг үг хэллэг, нэр томъёо, хууль дүрэм, химийн холбоо, онол хэрэглээний тайлбарыг оруулсан болно. Уг лавлах нь химийн мэргэжлээр ажиллаж байгаа судлаачдын гадаад хэлний боловсролыг нэмэгдүүлэх, ялангуяа магистрант, докторант, химийн багш, судлаачид, их дээд сургуулийн оюутнуудад үг хэллэгийг сайжруулахад туслах зорилготой ажээ.

24я2

А-298

/БУН унш-4ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-28414-28415



**Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, судалгааны цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм = Хүдрийн олборлолт, боловсруулалтаас үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн дүрэм /** Эмхт. Э.Нямдаваа; Хян. Г.Манлайжав.- УБ., 2018.- 56х.- (Цөмийн энергийн комисс).

Энэхүү товхимолд Цөмийн энергийн комиссоос гаргасан цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, судалгааны цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм болон хүдрийн олборлолт, боловсруулалтаас үүсэх цацраг идэвхт хаягдлын менежментийн талаар мөрдөх хууль, дүрэм, журмыг оруулжээ.

26.341

Ц-263

ЭШФ Т-21492-21493

## **БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН**

Мандах Б. **Дорнод Монголын хээрийн ургамлын ценопопуляци** / Хян. И.Түвшинтогтох.- УБ.: Адмон принт, 2016.- 149х.- ISBN 978-99978-4-071-4.



Энэхүү номонд ургамлын биоморфологийн судалгааны зарим аргазүй, Дорнод Монголын хээрийн үндсэн 3 бүлгэмдлийн бүтэц, бүрэлдэхүүн, улирлын хөгжлийн явц, тэнд зонхилгогч 5 зүйл ургамлын онтогенез буюу амьдралын их эргэлт, ценопопуляцийн бүрэлдэхүүнийг судалсан дүнг тусгажээ. Энэ бүтээлийг ургамал судлаач, биологич, экологич, ургамал судлалын чиглэлээр суралцаж байгаа оюутнуудад болон байгаль сонирхогчидод зориулав.

28.5(1-M7)

М-216

ЭШФ Т-21099



Дашжамц Я. **Чингэлтэй дүүрэг орчмын байгалийн ургамалыг нөхөн сэргээх арга: Өнгөт зургийн цомог: Цуврал-8 / Хян. Ч.Дугаржав, Ц.Жамсран, Ц.Цэндээхүү.- УБ.: Виндзор, 2017.- 160х.- ISBN 978-99978-898-0-5.**

Чингэлтэй дүүрэг нь “Эрдэм ном-Эд баялаг”-ийн бэлгэдэлт Чингэлтэй хайрханаараа овоглодог юм. Эрдэмтэн, судлаач Я.Дашжамц энэхүү номондоо байгалийн тэнцвэр, эко системийн төрөл зүйл болох олон төрлийн мод, бут, сөөг зэрэг 52 овгийн 181 төрлийн 347 зүйл ургамалын тухай өнгөт, зурмал хэлбэрээр мөн гэрэл зургаар баримтжуулан оруулжээ.

28.58(1-5)+44

Д-394

ЭШФ Т-21444-21445

Галиндэв Б., Цэрэнсүрэн Х. **Лабораторийн амьтан судлал-1: Сурах бичиг, гарын авлага / Хян. Б.Бурмаажав, Ж.Бэх-Очир, Ц.Бямбажав ба бус.- УБ.: Удам соёл, 2017.- 176х.- (Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль. Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв).- ISBN 978-99962-76-39-2.**



Энэхүү ном нь лабораторийн амьтны хэрэглээтэй холбоотой сүүлийн үеийн материалыг цуглуулж туршилтын ажлын туршлага, лабораторийн амьтны судалгааны байдал хэрэглээтэй холбоотой мэдлэгийн санг баяжуулах зорилгоор цогц хэлбэрээр эмхэтгэн бичсэн мэргэжлийн чиглэлийн анхны сурах бичиг юм. Уг сурах бичигт төрөл бүрийн лабораторийн амьтны үүлдэр, анатоми, физиологи, тэжээх менежмент, туршилтын амьтныг егүүтгэх арга, тусламж үзүүлэх, тээвэрлэлт 3R онол зэргийг багтаасан байна.

28.6я73

Г-199

/БУН унш-5ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21352-21352



Галиндэв Б., Цэрэнсүрэн Х. **Лабораторийн амьтан судлал-2: Сурах бичиг, гарын авлага / Хян. Г.Батбаатар, Б.Бурмаажав, Б.Мөнхбат ба бус.- УБ.: Удам соёл, 2017.- 176х.- (Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль. Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв).- ISBN 978-99962-76-39-2.**

“Лабораторийн амьтан судлал-2” номыг бичихдээ лабораторийн амьтны хэрэглээтэй холбоотой ихэнх хэсгийг Хятад хэл дээрх номноос сүүлийн үеийн материалыг цуглуулж, туршилтын ажлын туршлага, бусад эрдэмтдийн судалгааны ажлын тайлан зэргийг үндэслэжээ. Энэхүү 2-р дэвтэрт лабораторийн амьтанд эмгэг загвар үүсгэх тухай, амьтны тэжээл, амьтанд түгээмэл тохиолдох халдварт өвчин, туршилтын үйл ажиллагааны технологи зэрэг 4 бүлгийг багтаасан байна.

28.6я73

Г-199

/БУН унш-5ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21354-21355

Болдбаатар Ш. **Улаанбаатар хот, орчмын нутгийн шувуу** / Ред. Д.Баатар.- УБ., 2016.- 142х.- ISBN 978-99978-4-22-0.



Монгол орны шувуу судлалын нэгээхэн хэсэг нь суурин газрын шувууны судалгаа бөгөөд түүний хөгжлийн түүх өөрийн өвөрмөц онцлогтой юм. Бөөгийн шашин унаж XVI зууны үеэс шарын шашин дэлгэрэх болсноор Монгол газар нутагт сүм хийд олноор баригдаж суурин амьдралын нөхцөл сайжирч эхэлсэн нь хүнд ойромсог шувууны олон янз бүрдэл бий болоход нөлөөлсөн байна. Энэхүү номонд манай орны хамгийн том, хүн ам нягт суурьшсан нийслэл хот болох Улаанбаатар, түүний орчим нутгийн шувууны тухай олон талаас нь тайлбарлан өгүүлнэ.

28.693.35(1-2УБ)

Б-547

ЭШФ Т-21115



**Монгол орны хөхтөн судлалын бүтээлийн жагсаалт** / Эмхт. Ц.Мөнхзул, Г.Цогтжаргал, Г.Наранбаатар ба бус.; Ред. Я.Адъяа, Б.Лхагвасүрэн.- УБ.: Наруд Дизайн, 2016.- 224х.

Монгол орны амьтны аймгийн чухал бүрэлдэхүүн хэсэг хөхтний төрөл зүйлийг тогтоох, тархац, тоо толгойн хөдлөл зүй, биологи экологийн онцлог, экосистемийн тэнцвэрт байдал, нөөц баялагийг хамгаалах, тогтвортой ашиглах зэрэг шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах чиглэлээр манай үе үеийн хөхтөн судлаачид бие даан болон гадаадын эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдолтой олон зуун эрдмийн бүтээлийг туурвижээ. Энэхүү ном нь Монгол орны хөхтний судалгааг хийсэн гадаад дотоодын эрдэмтэн судлаачдын эрдмийн бүтээлийн жагсаалтыг нэгтгэн эмхэтгэсэн бүтээл юм.

91.9:2

М-692

ЭШФ Т-21112

### ГАЗАР ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Нацагдорж Л. **Синоптик цаг уур**: Сурах бичиг / Хян. З.Батжаргал.- УБ.: Адмон, 2017.- 667х.- ISBN 978-99978-1-041-0.



Энэхүү сурах бичигт цаг уурын ажиглалтын анхдагч өгөгдлийг синоптикийн шинжилгээ, прогнозын зориулалтаар зохистой хэлбэрээр дүрслэх, цаг уурын хэмжигдэхүүний том хэмжээст орны үндсэн үзүүлэлтүүдийг авч үзээд үүнээсээ уламжлан синоптикийн байгууламжуудын үүсэл хувьсал, шилжилтийн онол, практикийн асуудлыг тодорхойлсныхоо үндсэн дээр цаг уурын үндсэн хэмжигдэхүүнийг богино хугацаагаар урьдчилан тооцоолох арга, технологийн асуудлыг дэлгэрэнгүй өгүүлжээ.

26.23я73

Н-34

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-20878-20880





**Бүс нутгийн экосистемд түшиглэсэн дасан зохицохуйн арга хэмжээний сайн туршлага, аргачилсан зөвлөмж** / Боловс. С.Эрдэнэсүх, Д.Оюунбаатар, Б.Эрдэнэцэцэг ба бус.; Хян. Ц.Туяа, Ж.Сумъяасүрэн, Д.Цогнамсрай, Н.Отгонжаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 210х.- ISBN 978-99978-1-978-9.

Биологийн төрөл зүйл ба экосистемийн үйлчилгээг уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицохуйн бусад стратеги, арга технологитой нэгтгэн хэрэглэж буй дасан зохицохуйн нэгэн арга, хэлбэрийг Экосистемд Түшиглэсэн Дасан Зохицохуй (ЭТДЗ) хэмээн тодорхойлдог. Уг товхимолд зорилтот бүс нутаг болох Хархираа, Түргэн голуудын дэд сав газар болон Улз голын сав газрын байгаль орчин, нийгэм эдийн засагт ЭТДЗ арга хэмжээний оруулсан хэвь нэмрийг эмхэтгэн хүргэж байна.

26.237

Б-885

/БУН унш-10ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21387-21391

Адъяасүрэн П., Сарантуяа С. **Геохими**: Их дээд сургуулийн оюутан, магистрант, судлаачдад зориулав / Ерөн. ред. Г.Сүхдорж.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 281х.- ISBN 978- 99978-1-968-0.



Тус сурах бичгийг геологи, хими, биологи, газар зүй, экологийн дагнасан чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудын оюутнуудад зориулж бичсэн болно. Сурах бичигт дэлхийн геомандалд байгалийн химийн элементүүдийн шилжин тархах зүй тогтол, геохимийн саатлаар хуримтлагдаж ашигт малтмалын орд хэлбэржих зүй тогтлуудыг судлахад онцгой үүрэг бүхий хоёр чухал асуудлыг онцлон авч үзжээ.

26.30я73

А-297

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-21432-21434



**Жамбалжав Я. Монгол орны цэвдгийн тархалт, өөрчлөлт** / Ред. Д.Дашжамц.- УБ.: Колорфул ХХК., 2017.- 80х.- ISBN 978-99978-1-862-1.

Энэхүү нэг сэдэвт бүтээл нь цэвдэг судлалын шинжлэх ухааны зарим нэр томъёоны тайлбар тодорхойлолтыг өгөхөөс гадна Монгол орны хэмжээнд сүүлийн үед хийсэн судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан цэвдгийн тархалт өөрчлөлт, термокарст, термокарстын нуур, бөөрөг зэрэг криоген үзэгдлийн судалгааны үр дүнг товчлон оруулсан болно. Уг номыг тухайн чиглэлээр суралцагчид, судалгааны ажилтан нар гарын авлага болгон ашиглах боломжтой ажээ.

26.36(1)

Ж-23

Т-20646-20648

Бадамсүрэн Ж., Эрдэнэчимэг Д. **Эрдэс, түүхий эдийн химийн шинжилгээ**  
/ Ред. Б.Цэндээ.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2017.- 157х.



Энэхүү номонд химийн шинжилгээний жингийн, эзэлхүүний, фотометрийн зэрэг химийн уламжлалт суурь анализын аргуудыг ашиглан эрдэс түүхий эдэд шинжилгээ хийх аргачлалуудыг онол, арга зүйтэй нь холбон нэгтгэн бичжээ. Тус номонд хавсралтаар нэмж фотометрийн аргаар шинжилгээ хийхэд шаардлагатай хялбарчилсан хүснэгтийг гаргах аргачлалыг жишээгээр гарган үзүүлэв.

26.342+26.31

Б-15

/БУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-20875-20877

### **ТЕХНИК БА ТЕХНИКИЙН ШИНЖЛЭХ УХААН**



**Мэдээлэл, холбооны технологи боловсролд:** Монголын мэдээллийн технологи-2017 эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.- УБ.: ШУТИС-ийн хэвлэлийн газар, 2017.- 239х.- ISBN 978-99978-57-26-2.

Монголын Мэдээллийн Технологийн Консорциумаас санаачилсан “Монголын Мэдээлэл Технологи” эрдэм шинжилгээний хурал 5 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү бүтээлд “Мэдээлэл, холбооны технологи боловсролд”, “Дүрс боловсруулалт, дүрслэл”, “Их өгөгдөл”, “Дохио боловсруулалт”, “Мэдээллийн технологийн хэрэглээ”, “Удирдлагын систем” гэсэн 6 салбар хуралдаанаар тавигдсан илтгэлүүдийг эхмэтгэжээ.

З

М-695

ЭШФ Т-21066-21067

Магванжав Б., Цогтбаатар Ч. **Монгол улсын уул уурхай-95:** Монголын уул уурхайн түүхэн хөгжлийн жим / Ред. Д.Өлгийсайхан.- УБ.: Интерпресс, 2017.- 750х.




Энэхүү номонд Монгол улсад уул уурхайн салбар үүсч хөгжсөний 95 жилийн ойг тохиолдуулан уул уурхайтай холбоотой үе үеийн эрдэмтэн судлаачид, ахмадуудын бүтээл туурвил, дурсамж, тэмдэглэл, түүхэнд болсон үйл явдлыг аль болох бодит баримтанд тулгуурлан бичсэн байна.

33.1(1)+65.304.11(1)

М-113

ЭШФ Т-21533





**Монгол улсын алтны салбар, хөгжлийн хэтийн төлөв** / Ред. Д.Галсандорж.- УБ.: Адмон принт, 2016.- 142х.- ISBN 978-99973-0-960-0.

Өнөөдөр Монгол улсын алтны нийт нөөц 2000.0 гаруй тонн болоод байна. МУҮСХорооны 2015 оны 10 дугаар сарын мэдээгээр алтны салбар нь ДНБ-ний 2.6 хувь, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн 9.6 хувь, экспортын орлогын 9.1 хувийг эзэлж байна. Тус номонд “Алт” хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, алтны салбарын үйл ажиллагаа, алтны гадаад зах зээл, алт олборлох болон боловсруулах технологи, алтны салбарт тулгамдаж буй асуудал, бодлогын зорилт, нөхөн сэргээлт зэргийг тусгажээ.


33.3(1)

М-692

ЭШФ Т-21109

### **ХӨДӨӨ АЖ АХУЙ БА ОЙН АЖ АХУЙ**

**Монголын хөрс судлал 2017(02) = Mongolian journal of soil science** / Эрхл. О.Батхишиг.- УБ.: Удам соёл, 2017.- 189х.- (Хөрс Судлалын Холбоо).- ISSN 2522-1604.



“Дэлхийн хөрсний өдөр”-ийг жил бүрийн 12-р сард тэмдэглэх болсонтой холбогдуулан 2016 оны 12-р сарын 15-нд “Монгол орны хөрс судлал-2016” үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний бага хурлыг судлаач, эрдэмтэн, оюутан сурагчдын дунд зохион байгуулсан билээ. Энэхүү эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал нь Монгол орны хөрс судлаач болон хөрсний асуудлыг сонирхож буй хүмүүс санал бодлоо солилцох, өөрсдийн судалгааны ажлын үр дүн, мэдлэг туршлагаа бусадтай хуваалцах, цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлыг хөндсөн нь Монгол орны хөрс судлалын шинжлэх ухааны хөгжлийг эрчимжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болжээ.

40.3(1)

М-692

/БУН унш-3ш/

ЭШФ Т-21374-21375



**Доржсүрэн Ч. ба бус. Ойн нэр томьёоны товч тайлбар толь** / Ч.Дугаржав, Ц.Чулуунбаатар; Ерөн. ред. М.Тунгалаг.- 2 дахь хэвл.- УБ.: Адмон принт, 2017.- 320х.- ISBN 978-99978-1-950-5.



Тус номонд ойн мэргэжлийн нэр томьёоны үг хэллэг, тодорхойлолт, ойн хомсдол, доройтол, ойн хүлэмжийн хийн ялгарал, шингээлттэй холбоотой нэр томьёог монгол болон англи хэлний товч тайлбартайгаар оруулсан байна. Энэхүү номыг Монгол орны ой модны салбарт ажиллаж буй мэргэжилтэн, ажиллагсад, оюутан сурагчид, эрдэм шинжилгээний ажилтан нарт зориулжээ.

43я2

Д-54

/БУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Б-28139-28141

Максвелл Ж. **Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн гарын авлага** / Орч. Б.Сосорбарам; Хян. Б.Сувд, П.Ундармаа.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 331х.- ISBN 0-942364-50-3.



Энэхүү эрүүл мэндийн гарын авлагад хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хэрхэн сайн асаргаа, халамж үзүүлэх, тэдэнд тохиолдох бэрхшээлүүд, жирэмсэн үеийн эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ээлтэй эрүүл мэндийн туслаж үйлчилгээг хэрхэн бий болгох зэрэг асуудлыг хөнджээ.

51.2я7

М-158

/НУН унш-3ш/

ЭШФ Т-21494-21496

### НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН



Наранцогт Т. **Эрх зүйн социологи: Гарын авлага**.- УБ.: ЗГ-ын хэвлэх үйлдвэр, 2018.- 82х.- ISBN 978-99978-2-701-2.

Хуулийг боловсронгуй болгох, түүний хэрэгжилт, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор амьд эрх зүйг судалдаг эрх зүй болон социологийн шинжлэх ухааны салбар дундын судлагдахуун болох эрх зүйн социологи хичээлийн гарын авлагыг хүргэж байна. Уг бүтээлийг эрх зүйн социологийг сонирхон суралцаж байгаа хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, суралцагсадад

зориулав.

60.56

Н-294

/ХЗС-30ш/

**Ядуурлын дүр төрх-2016:** Өрхийн нийгэм, эдийн засгийн 2016 оны судалгааны үр дүн.- УБ., 2017.- 148х.- (Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо).




Үндэсний Статистикийн Хорооноос эрхлэн гаргасан энэ тайланд “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа”-нд 2016 онд хамрагдсан 16000 гаруй өрхийн мэдээлэлд үндэслэн ядуурлын өнөөгийн түвшин, ядуурлын хамралтад гарч буй өөрчлөлтийн шинжилгээ хийж, бодитой тоон мэдээллийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар тооцон гаргажээ. Энэхүү судалгаа нь сонирхсон хэн бүхэнд хамгийн сүүлийн үеийн бодит мэдээлэл, гарын авлага болох юм.

60.56(1)

Я-38

Т-20618-20619



**Монгол улсын статистикийн эмхэтгэл 2016** / Эмхт. Л.Хануй; Хян. А.Ариунзаяа, Ч.Баянчимэг, А.Дэмбэрэл, М.Ганчимэг.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 652х.- ISBN 978-99978-801-1-6.

Энэ удаагийн Монгол улсын статистикийн эмхэтгэлд Монгол улсын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн 2016 оны эмхэтгэлийг өмнөх есөн жилийнхтэй харьцуулан 10 жилээр гаргасан байна. Статистикийн эмхэтгэлийг хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй болгох зорилгоор үзүүлэлтийг тооцох аргачлал, нэр томъёоны тайлбар, тухайн салбарын онцлох мэдээллийг бүлэг бүрийн өмнө тодотгож, нийгэм эдийн засгийн салбаруудын таних тэмдгийг байршуулжээ.

60.6(1)

М-692

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21451-21453

### ТҮҮХ, ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Баабар. **Монгол түүх:** Боть-1: Талын морьтон баатрууд / Редакцийн зөвл. Д.Баярхүү, Ч.Болдбаатар, Л.Хангай, Б.Цэнддоо.- 3 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2017.- 265х.- ISBN 978-99978-51-16-1.




Монгол улсын түүхийн эхний боть болох “Талын морьтон баатрууд” номонд талын монголчуудын эртний түүх, домог, зураг бичээс, түүхийн эхэн үеийн тэмдэглэгээ, Төв Азийн нүүдэлчид, Умрын зэрлэгүүд, Монголын эзэнт гүрэн, түүний дараах үе, Манжийн захиргааны Монголын талаар зохиогчийн эрэл хайгуул, судалгааны цуглуулга, түүхийн баримт, нотолгоонд суурилсан, сонирхолтой, ойлгомжтой өгүүлжээ. Энэхүү бүтээлийн гурав дахь хэвлэлийг уншигч танаа толилуулж байна.

63.3(1)

Б-101

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20970-20972



Баабар. **Монгол түүх:** Боть-2: Хутагтууд ба хувьсгалчид / Редакцийн зөвл. Д.Баярхүү, Ч.Болдбаатар, Л.Хангай, Б.Цэнддоо.- 3 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2017.- 277х.- ISBN 978-99978-51-16-1.

Монгол улсын түүхийн дэд боть болох “Хутагтууд ба хувьсгалчид” номонд XX зууны Монголын тусгаар тогтнолоо сэргээсэн түүх, Монголын талаархи Орос-Хятадын бодлого, Гурван улсын гэрээ, ардын хувьсгалын өрнөл, тэмцэл, хувьсгалын дараах Оросын бодлогын талаар зохиогчийн эрэл хайгуул, судалгааны цуглуулга, түүхийн баримт, нотолгоонд суурилсан, сонирхолтой, ойлгомжтой өгүүлжээ. Энэхүү бүтээлийн гурав дахь хэвлэлийг уншигч танаа толилуулж байна.


63.3(1)

Б-101

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20973-20975

Баабар. **Монгол түүх**: Боть-3: Тоглоомын Бүгд Найрамдах Улс / Редакцийн зөвл. Д.Баярхүү, Ч.Болдбаатар, Л.Хангай, Б.Цэнддоо.- 3 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2017.- 277х.- ISBN 978-99978-51-16-1.




Монгол улсын түүхийн гутгаар боть болох “Тоглоомын Бүгд Найрамдах Улс” номонд Гадаад Монголын талаархи Зөвлөлт, Хятадын бодлого, Зөвлөлтөөс Монголд явуулсан бодлого, коммунист хийрхэл, үндэсний сэхээтнүүдийн их хядлага, Халх голын тулаан, Дэлхийн II дайн, Монгол дахь Японы сонирхол, Монгол улс тусгаар тогтнолоо зарласан түүхийн талаар зохиогчийн эрэл хайгуул, судалгааны цуглуулга, түүхийн баримт, нотолгоонд суурилсан, сонирхолтой, ойлгомжтой бичжээ. Энэхүү бүтээлийн гурав дахь хэвлэлийг уншигч танаа толилуулж байна.

63.3(1)

Б-101

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20976-20978



Баабар. **Монгол түүх**: Боть-4: Иргэншил, түүний өртөг / Редакцийн зөвл. Д.Баярхүү, Ч.Болдбаатар, Л.Хангай, Б.Цэнддоо.- 3 дахь хэвл.- УБ.: Нэпко, 2017.- 268х.- ISBN 978-99978-51-16-1.

Монгол улсын түүхийн дөтгөөр боть болох “Иргэншил, түүний өртөг” номонд 1946 оноос хойшхи Ар, Өвөр Монголыг нэгтгэх Х.Чойбалсангийн оролдлого, Зөвлөлт-Хятадын хоорондох социалист Монгол, НҮБ-д элсэх үеийн саад бэрхшээл, соёлын хувьсгал, нэгдэлжих хөдөлгөөн, коммунизмын сүйрэл, ардчилсан хувьсгалын 1990 он хүртэл түүхийн талаар зохиогчийн эрэл хайгуул, судалгааны цуглуулга, түүхийн баримт, нотолгоонд суурилсан, сонирхолтой, ойлгомжтой бичигджээ. Энэхүү бүтээлийн гурав дахь хэвлэлийг уншигч танаа толилуулж байна.

63.3(1)

Б-101

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20979-20981

Болдбаатар Ж. **XX зууны Монгол улс = 20th century Mongolia**: Хувьсгалт өөрчлөлт, сэргэн мандалтын замд = the road to revolution and renewal: 1921-1952 / Ред. Д.Сүхбаатар; Орч. Б.Дашдулам; Орч. ред. Л.В.Бартон, Ф.Женнифер.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 258х.- ISBN 978-99978-1-280-3.




Монголын Үндэсний музейгээс өөрийн сан хөмрөгт байгаа үзмэрүүдийг шинжлэх ухааны тайлбартайгаар хэвлэн нийтлэх ажлын хүрээнд хийгдэж буй цувралын энэ удаагийн хэвлэлд 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалаас 1950-иад оны эх хүртэл, тухайлбал “Социализмыг дэлгэрэнгүй байгуулах зорилт” дэвшүүлсэн МАХН-ын XII их хурал хүртэл хугацааг хамарсан түүхийн үзмэрийн каталогийг боловсруулан монгол-англи тайлбартайгаар гаргажээ.

63.3(1)

Б-54

ЭШФ Т-20644



**Гадаад Монголын тусгаар тогтнолын нууц учир** / Эмхт. Ч.Алтангэрэл;  
Ред. Х.Батхүү.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 476х.- ISBN 978-99962-2-649-6.

Энэ номонд Монгол үндэстний үүслээс аваад, 1993 оны эх хүртэлх үе, тухайн тухайн үеүдийн дотоод, гадаад түүхэн нөхцөл байдлуудыг тусган харуулжээ. Уг ном нь Монголын хил хязгаар бүрэлдэн тогтсон тухай, Оросын эзэнт гүрний Дорнодахин, Монгол, Манжийн эсрэг явуулж байсан эзэрхэг түрэмгий дайн байлдаан, Манж-Хятадын зүгээс Монголын талаар баримталсан харгис бодлого, ЗХУ, АНУ, Английн удирдагчдаас Монголын тусгаар тогтнолыг хэрхэн хамгаалж байсан зэрэг зарим түүхэн чухал баримтуудыг сөхөж гаргасан бөгөөд түүхийн дээж бичигт тулгуурлан Гадаадмонгол Хятадаас салж бүрэн тусгаар тогтносон явцыг бодитойгоор, бүрэн гүйцэд, системтэй тусган харуулж, хүмүүсийн мэдвэл зохих дарагдаж байсан нууц, үнэнийг дэлгэн тавьсан байна.


63.3(1)5

Г-132

/НУН унш-4ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-28411-28413

**Фазлуллах Р. Шашдирын чуулган хэмээх Монголчуудын түүх оршивой:**  
**Тэргүүн боть** / Орч. Г.Аким.- 3 дахь хэвл.- УБ.: Ган принт, 2018.- 384х.- ISBN 978-99978-933-3-8.




XIII зууны эцэс, XIV зууны эхэн үед Монголын Ил хаант улсын Хасан хааны удирдлагаар түшмэл Рашидаддины туурвисан “Шашдирын чуулган” хэмээн энэхүү бүтээлийг англи хэлнээс Г.Аким орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт хийжээ. Хасан хааны удам нь Чингис хаан-Тулуй-Хулагу-Абага-Аргун-Хасан болой. Хасан хаан бээр олон хэлний мэргэд, орчуулагчдыг хураан чуулгаж, бас 1286 онд Монголын Юань гүрнээс Болд чинсан хэмээх бичгийн монгол хүнийг түүх шастирын хамт авчирсан нь баримттай бөгөөд "Алтан дэвтэр" хэмээх Чингис хаантныг өвөг дээдэстэй нь багтаасан түүхэн сурвалжийг ашигласан нь үнэн магад юм.

63.3(1)

Ф-16

/НУН унш-7, ГНОФ-10ш/

ЭШФ Б-28155-28157



**Фазлуллах Р. Шашдирын чуулган хэмээх Монголчуудын түүх оршивой:**  
**Дэд боть** / Орч. Г.Аким; Хян. Л.Пүрэвдорж.- 3 дахь хэвл.- УБ.: Ган принт, 2018.- 687х.- ISBN 978-99978-933-4-5.

Г.Акимын англи хэлнээс орчуулж, уялга үг бичиж, тайлбар зүүлт үйлдсэн энэхүү бүтээл нь 11 бүлэг, бүлэг бүр 3-4 хэсгээс бүрджээ. Уг шашдирын чуулганд Чингис хааны цадигийг 615 оны Дул-хада сарын шинэдтэй (1219 он) таацах туулай жилийн эхнээс 624 оны сафар сарын шинэдтэй таацах гахай жилийн эхэн (1227 он) хүртэл есөн жилээр өгүүлэхийн хамт, Чингис хааны хөвгүүн Өгэдэй хааны цадиг, Жочи ханы цадиг, Цагадай хааны цадиг, Толуй хааны цадиг, Өгэдэй хааны хөвүүн Гүюүг хааны цадиг, Толуй хааны хөвүүн Мөнх хааны цадиг, Хувилай хааны



цадиг, Чингис хааны хөвүүн Толуй хааны хөвүүн, Хувилай хааны хөвүүн Жимгимийн хөвүүн, Төмөр хааны цадиг хэмээх монголчуудын түүхийг өгүүлжээ.

63.3(1)

Ф-16

/НУН унш-7, ГНОФ-10ш/

ЭШФ Б-28158-28160

Түмэнжаргал Д., Мэндсайхан Т. **Элжигэн халхын түүх**: Нэгдүгээр дэвтэр / Хян. Ц. Ишдорж, Л.Гомбожав.- УБ.: Ном хур, 2017.- 306х.




“Элжигэн халхын түүх” хэмээх энэхүү гурамсан ном нь Элжигэн нутгийн ард түмний нүүдлийн иргэншил, шүтлэг бишрэл, зан заншил, соёл ахуй, цаг үеийн байдал, улс төрийн харилцаа зэрэг олон асуудлыг агуулсан байна. Энэ номонд Элжигэн угсаатан болон Элжигэн хоёр хошууны нэн эртнээс өнөөдрийг хүртэлх түүхэн хөгжлийн олон асуудлыг хөнджээ. 1-р дэвтэрт Элжигэний угсаа гарлаас эхлэн Манжийн харьяалалд нийт Халх, Дөрвөд, Ойрадын зарим аймаг хошуудын хамт орж, захирагдан шинээр хошуу байгуулагдсан үеэс эхлэн нилээн дэлгэрэнгүй бичжээ.

63.3(1)

T-784

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21328-21330



Түмэнжаргал Д., Мэндсайхан Т. **Элжигэн халхын түүх**: Хоёрдугаар дэвтэр / Хян. Ц. Ишдорж, Л.Гомбожав.- УБ.: Ном хур, 2017.- 334х.

“Элжигэн халхын түүх” хэмээх энэхүү гурамсан ном нь Элжигэн нутгийн ард түмний нүүдлийн иргэншил, шүтлэг бишрэл, зан заншил, соёл ахуй, цаг үеийн байдал, улс төрийн харилцаа зэрэг олон асуудлыг агуулсан байна. Энэ номонд Элжигэн угсаатан болон Элжигэн хоёр хошууны нэн эртнээс өнөөдрийг хүртэлх түүхэн хөгжлийн олон асуудлыг хөнджээ. 2-р дэвтэрт 1911, 1921 оны хувьсгалд тус хошууны ард олон хэрхэн оролцсоноос эхлэн 1931 онд хошуу тарж, 3 сум болон салж, одоогийн Увс аймагт харьяалагдах хүртэлх түүхийг оруулжээ.

63.3(1)

T-784

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21331-21333

Түмэнжаргал Д., Мэндсайхан Т. **Элжигэн халхын түүх**: Гуравдугаар дэвтэр / Хян. Ц. Ишдорж, Л.Гомбожав.- УБ.: Ном хур, 2017.- 324х.



“Элжигэн халхын түүх” хэмээх энэхүү гурамсан ном нь Элжигэн нутгийн ард түмний нүүдлийн иргэншил, шүтлэг бишрэл, зан заншил, соёл ахуй, цаг үеийн байдал, улс төрийн харилцаа зэрэг олон асуудлыг агуулсан байна. Энэ номонд Элжигэн угсаатан болон Элжигэн хоёр хошууны нэн эртнээс өнөөдрийг хүртэлх түүхэн хөгжлийн олон асуудлыг хөнджээ. 3-р дэвтэрт Элжигэний эрхлэх аж ахуй, гэрийн үйлдвэрлэл, гар урлал, наадам цэнгэл, найр хурим, уламжлалт эдлэл хэрэглэл, гоёл чимэглэл, соёл зан заншлын онцлогийг дэлгэрэнгүй оруулжээ.



63.3(1)  
Т-784

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21334-21336



**Улс төрийн хэлмэгдүүлэлт:** Шалтгаан, үр дагавар, сургамж: Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл / Эмхт. П.Нарандалай, П.Оюун.- УБ., 2017.- 397х.

Энэхүү бүтээлд улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр, Их хэлмэгдүүлэлтийн 80 дахь жилийн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар хүмүүсийн хэлсэн үг, Олон улсын эрдэм шинжилгээний бага хуралд тавьсан эрдэмтэн судлаачдын илтгэлүүдийг нэгтгэн эмхэтгэсэн байна. Энэ эрдэм шинжилгээний хурлаар Монголчуудын туулж өнгөрүүлсэн XX зууны хамгийн эмгэнэлт түүх хэлмэгдүүлэлтийн зарим асуудлуудаар санаа бодлоо солилцон, хэлэлцэж улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг энэ цаг үед амьдарч буй хүн бүрийн сонорт хүргэн олон нийтэд тайлбарлан таниулах, өөр хэлбэрээр дахин давтан үүсч гарахаас урьдчилан сэргийлэх улмаар хэлмэгдүүлэлт судлалыг түүхийн болон шинжлэх ухааны талаас авч үзэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг барагдуулах, цагаатгалын үйл ажиллагааг үргэлжлүүлэх зэрэг асуудлыг хэлэлцжээ.

63.3(1)-4  
У-31

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20994-20996

Болдбаатар Ж. **Монгол түмний сод хүмүүс:** Монголын төр, аж ахуйн зүтгэлтнүүд: Боть-3 / Хян. С.Даваасүрэн.- УБ.: Соёмбопринтинг, 2018.- 635х.- (Шинжлэх Ухааны Академи. Түүх, Археологийн Хүрээлэн).- ISBN 978-99978-2-164-5.



Түүхэн хүмүүсийн тухай цуврал бүтээлийн энэ ботид Монголын аж ахуй, эдийн засаг, тэр дундаа аж үйлдвэр, худалдаа, санхүүгийн түүхийг нэн эртний үеэс өнөөдрийг хүртэл иж бүрнээр тоймлон үзүүлж, тэртээ ХҮИ-ХҮП зууны төрийн нэрт зүтгэлтэн То вангийн аж ахуйн бодлого, ухаанаас эхлэн өнөө ч үйл хэргээ үргэлжлүүлсээр яваа улс төр, бизнесийн зүтгэлтнүүдийн замнал, намтрыг багтаажээ.

63.3(1)-8  
Б-54

ЭШФ Т-21021-21022



Камингс Б. **Солонгосын дайн:** Түүх / Орч. Ж.Батбаяр.- УБ.: Нэпко, 2010.- 353х.- ISBN 978-99978-51-24-6.

Энэ ном нь мартагдсан буюу хэзээ ч олны танил болоогүй дайны тухай өгүүлж, улмаар үнэн баримт нотолгоонд түшиглэх тул бас түүх, дурсамжийн тухай ном юм. Номын гол сэдвүүд нь уг дайны Солонгос дахь үүсэл, 1950-иад оны эхэн үед Америкт гарч байсан соёлын зөрчилдөөн, хязгаарлагдмал гэгдэх уг дайнаар тэнгэрээс болон газар дээр үйлдсэн зүрх шимшрэм харгис явдал, тухайн түүхийн явцад дахин сэргэсэн Өмнөд Солонгос болон энэ

үл мэдэгдэх дайн Америкийн байр суурийг дэлхийд, түүхэнд, дурсамжинд хэрхэн өөрчилсөн зэрэг юм. Америкийн утга зохиолд Солонгосын дайны талаар нэлээд тодорхой бичсэн ном гэвэл Рой Эпплманы туурвисан түүхийн хэдэн боть, Клэй Блэйрийн “Мартагдсан дайн” мөн энэхүү “Солонгосын дайн” ном юм.

63.3(5Сo)

К-182

/НУН унш-5ш/

ЭШФ Б-28394-28398

Цогту О. **Монгол хүн ба соёлын хувьсгал** / Монгол бичгээс хөрв. Э.Пүрэвжаргал; Ред. С.Ууганбаяр УБ.: Монсудар, 2017.- 571х.- ISBN 978-99973-1-512-0.



Энэхүү номонд БНХАУ-д 1966-1976 оны хооронд явагдсан Соёлын Их Хувьсгалын үед Өвөр Монголчуудыг хэлмэгдүүлэн хядсан тухай өгүүлнэ. Тус номын зохиогч О.Цогту Соёлын хувьсгалын үед амьдарч, хэлмэгдэж байсан хүмүүсийн аман түүхийг судалгааны бүтээлүүдээр баяжуулан Өвөр Монголчуудыг хэлмэгдүүлэх болсон учир шалтгааны урьдач нөхцөл буюу Нармай Монгол улс байгуулахын төлөөх Өвөрмонголчуудын тэмцэл, Япончуудтай харилцаж байсан харилцаа зэргийг тодорхой өгүүлжээ.

63.4

Ц-75

ЭШФ Б-28142



Равдан Э. **Их Монгол гүрний хот, балгадын товчоон** / Хян. С.Чулуун, А.Очир, В.Батмаа ба бус.- УБ., 2018.- 274х.- ISBN 978-99978-2-441-7.

“Их Монгол гүрний хот, балгадын товчоон” номд Хубилай сэцэн хаан өвөг эцгийнхээ их үйлийг залгамжлахаар Бээжин хотноо зарларч 1331 онд их Монгол гүрнийхээ Баруун хил хязгаарыг тогтоох зорилгоор өөрийн харьяаны улс орон, хот, балгадыг заасан газрын зургийг Хуи Яо, Тан, Сүн улсын үеийн уламжлалыг загвар болгон бүтээлгэсэн Баруун улс орнуудын газрын зурагт багтсан өнөөгийн Цагаан хэрмийн баруун үзүүрээс одоогийн Саудын Араб хүртэлх монгол, перс, араб, түрэг, герег, армян зэрэг нийт есөн хэлний 105 улс орон, хот балгадын нэр, нөгөө нь Илхаадын үед 1520-иод оны үед бүтээсэн “Монгол уул, усны газрын зураг”-т орсон 211 нэрээс өдгөө бидэнд олдсон 200 орчим улс орон, хот, балгадын түүхийг өгүүлжээ.

63.4(1)

Р-131

/НУН унш-4ш, ГНОФ-4ш/

ЭШФ Т-21440-21443

**ЭДИЙН ЗАСАГ, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН**

**Мөнгө-Санхүү-Баялаг:** Эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл: 2017/01(1) / Сэтгүүлийн зөвлөлийн дарга Н.Баяртсайхан; Эрхл. Б.Болдбаатар.- УБ.: Адмон принт, 2017.- 148х.- ISSN 2521-1501.



“Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүлийн анхны дугаар хэвлэгдэн гарч байна. Энэхүү анхны дугаарт Монгол улсын банкны хоёр шатлалт тогтолцооны хөгжлийн туулсан зам, шинэчлэлийн эхлэл, хүртсэн сургамж, даван туулах сорилт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын манайд үзүүлж буй нөлөөллийн талаар дурдаж мөн хөрөнгийн урсгал, санхүүгийн тогтвортой байдал, мөнгөний ханш, өрийн дарамт, хүний хөгжлийн индекс, баялаг, эрчимтэй хөгжлийн талаарх судлаачдын санал, дүгнэлтийг тусгажээ.

65

М-811

ЭШФ Т-21478-21479



**Мөнгө-Санхүү-Баялаг:** Эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл: 2017/02(2) / Сэтгүүлийн зөвлөлийн дарга Н.Баяртсайхан; Эрхл. Б.Болдбаатар.- УБ.: Адмон принт, 2017.- 168х.- ISSN 2521-1501.

“Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүлийн энэ удаагийн дугаарт алт, зэс, нүүрсний үнэ, инфляцийн өсөлтийн шалтгаан, эдийн засгийн хүртээмжтэй өсөлт зэрэг асуудлыг хөнджээ. Мөн эдийн засгийн хямрал, хүний хөгжил, мөнгөний бодлого, алт хөтөлбөр, ядуурал зэрэг асуудлаар эрдэмтэн, судлаачдын тавьсан илтгэлийг нийтэлжээ.

65

М-811

ЭШФ Т-21480-21481

**Мөнгө-Санхүү-Баялаг:** Эдийн засгийн судалгаа, шинжилгээний сэтгүүл: 2018/01(4) / Сэтгүүлийн зөвлөлийн дарга Н.Баяртсайхан; Эрхл. Б.Болдбаатар.- УБ.: Адмон принт, 2018.- 143х.- ISSN 2521-1501.



Монголбанкнаас “Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд” сэдвийн хүрээнд “Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулган” зохион байгуулсан байна. Энэхүү сэтгүүлд холбогдох байгууллагын шийдвэр, зөвлөмж, дүгнэлт болон эрдэмтэн, судлаачдын бүтээлийг нийтэлжээ.

65

М-811

ЭШФ Т-21482-21484



Эрдэнэбат Б. **Хугацаан цуваан эконометрик**. - УБ.: Адмон, 2017.- 316х.- ISBN 978-99978-1-498-2.

Номын эхний бүлэгт эконометрикийн үндсэн ойлголтыг хураангуйлан оруулсан бол дараах хоёр бүлэгт хугацаан цуваан эконометрикт өргөнөөр ашиглагддаг компьютерийн програм болох EVIEWS, MATLAB-ын танилцуулга, 4-10-р бүлэгт МУИС-ийн болон Их Британы тэргүүлэх их сургуулиудад үздэг эдийн засгийн магистрын хөтөлбөрийн Хугацаан цуваан эконометрик хичээлийн агуулгыг багтаажээ. Энэ номыг ахисан түвшний бакалаврын болон магистр, доктор болон эмпирик судалгаа хийж байгаа судлаачдад зориулав.

65в6+22.1

Э-739

/НУН унш-5ш, ГНОФ-10ш/

ЭШФ Т-21382-21386

Чимгээ Д., Энэрэл А. **Өгөгдлийн шинжилгээ ба шийдвэр гаргалт EXCEL програм дээр гүйцэтгэх нь** / Ред. А.Болор.- УБ.: Арвай принт, 2018.- 144х.



Энэ ном нь их, дээд сургуулийн оюутнуудад хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээ, бизнесийн мэдээллийн систем зэрэг хичээлийг EXCEL програмын хэрэглээтэй холбон судлахад ашиглах сургалтын нэмэлт материал, гарын авлага болох юм. Мөн байгууллагын нягтлан бодогч, санхүүч, эдийн засагчид, бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалтын төслийн болон бизнесийн шинжилгээнд EXCEL програмыг ашиглахад нь туслах ажээ.

65с

Ч-620

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/

ЭШФ Б-28408-28410



Агваан Н. **Монгол улсын нягтлан бодох бүртгэл, аудит: Боть-1: Нягтлан бодох бүртгэлийн үндсэн онол ба санхүүгийн бүртгэл тайлагнал** / Ред. Л.Дамбадорж, Б.Сайнжаргал.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 603х.- ISBN 978-9997814012.

Энэхүү номын 1-р ботид нягтлан бодох бүртгэлийн үндсэн онол ба санхүүгийн бүртгэл тайлагналын онолыг жишээ бодлоготойгоор дэлгэрэнгүй тайлбарлажээ. Мөн нягтлан бодох бүртгэл, аудитын арга аргачлалын үндэс болж, чанартай бөгөөд нотолгоотой материаллаг бүртгэлийг бүрдүүлэх талаар энэ чиглэлээр ажиллаж, суралцаж буй хэн бүхэнд туслах чухал сурах бичиг болно.

65.052

А-214

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/

ЭШФ Т-20940-20942

Агваан Н. **Монгол улсын нягтлан бодох бүртгэл, аудит: Боть-2: Зардал өртгийн бүртгэл ба удирдахуйн шинжилгээ төлөвлөлт, хяналт** / Ред. Л.Дамбадорж, Б.Сайнжаргал.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 593х.- ISBN 978-9997814012.




Санхүүгийн бүртгэлийн төрөл ангилал дор зардал, өртгийг данслан бүртгэж, тооцоолох арга зүйг тайлбарладаг бол Удирдлагын бүртгэлийн хүрээнд тэрхүү зардал өртгийг ангилан судалж, шинжлэн цаашдын үе хугацаагаар төлөвлөн гүйцэтгэлд нь хяналт тавих аргачлалыг заадаг. Энэ ботийг уншиж судалснаар онол арга зүйн асуудлыг гүнзгийрүүлэн ойлгох, мэргэжлийн мэдлэг эзэмших боломжтой.

65.052

A-214

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/ ЭШФ Т-20943-20945



Агваан Н. **Монгол улсын нягтлан бодох бүртгэл, аудит: Боть-3: Аудитын онол арга зүй ба санхүүгийн тайлангийн аудит** / Ред. Р.Батжаргал, Ц.Жигдэн.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 432х.- ISBN 978-9997814012.

Энэхүү ном нь аж ахуйн газар байгууллагуудад хөтлөгдөн тайлагнагдаж буй хөрөнгө түүний эх үүсвэр болон үр дүнгийн байдлуудтай уялдсан бүртгэл, тайлагнал, төлөвлөлт, дотоод хяналтын байдлуудыг хөндлөнгөөс хэрхэн хянаж шалган, хараат бус зарчмаар үнэлэн дүгнэх онол арга зүй болоод арга аргачлалуудыг дэлгэрэнгүй тайлбарлажээ. Аудитын төрийн ба бизнесийн байгууллагын ажилтан аудиторуд, оюутан суралцагсад, магистрант, докторант судлаачдад зориулсан онол практик хосолсон цогц лавлагаа бүхий ширээний ном болно.

65.052

A-214

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/ ЭШФ Т-20946-20948

Агваан Н. **Монгол улсын нягтлан бодох бүртгэл, аудит: Боть-4: Төрийн ба бизнесийн байгууллагын санхүүгийн бүртгэл** / Ред. Л.Дамбадорж, Л.Дондог.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 650х.- ISBN 978-9997814012.



Дэлхий нийтээр зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа өнөө үед бизнесийн хэл болсон санхүүгийн бүртгэл тооцоо тайлагнал нь төрийн болон хувийн өмчийн аж ахуйн байгууллагын үйл ажиллагааны явцад хөрөнгө түүний эх үүсвэрийн өөрчлөлт хөдөлгөөнийг тусган харуулдаг. Иймээс энэ номонд төрийн ба бизнесийн байгууллагын ажлын онцлогтой уялдсан санхүүгийн бүртгэл тайлагналын нийтлэг болоод тусгай онол арга зүйг нэгтгэн тайлбарлажээ.

65.052

A-214

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/ ЭШФ Т-20949-20951





Агваан Н. **Монгол улсын нягтлан бодох бүртгэл, аудит: Боть-5: Нягтлан бодох бүртгэл аудитын судалгаа** / Ред. Л.Дондог.- 4 дэх хэвл. УБ.: Соёмбо принтинг, 2017.- 408х.- ISBN 978-99978-1401-2.


Дэлхий нийтээр зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа орчин үед бизнесийн хэл болсон санхүүгийн бүртгэл тооцоо тайлагнал төлөвлөлт, хяналтын онол арга зүйг шинэчлэх судалгааг бодитой бөгөөд тодорхой нотолгоонд тулгуурлан гүйцэтгэх шаардлагатай. Энэ номонд нягтлан бодох бүртгэл, аудитын онол арга зүйн шинэчлэл, арга аргачлалуудын өөрчлөлт хөгжлийг дэлгэрэнгүй тайлбарлажээ.

65.052

А-214

/НУН унш-4ш, ГНОФ-3ш, БС-10ш/ ЭШФ Т-20952-20954

Ганзориг Ө. **Санхүүгийн философи: Дэлхийн санхүүгийн түүх** / Ред. Р.Бигэрмаа.- Анхны хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 200х.- ISBN 978-99978-889-8-3.



Эдийн засгийн дэд бүтэц нь санхүүгийн зах юм. Санхүүгийн захын хөгжлөөс бид хүн төрөлхтний хөгжлийг харах төдийгүй энэ нь улс орон, компани, иргэн хүн бүрт нээлттэй ижил боломж олгодог экосистем бөгөөд түүнийг зөв ашиглаж чадвал хөгжлийн зэвсэг, эс чадвал мөхлийн шалтгаан болдог гэдгийг энэ номноос ойлгох болно.

65.26(0)

Г-21

ЭШФ Т-20649-20650



Лагнай Т. **Компанийн бондын санхүүжилтэд зэрэглэл тогтоох аргазүйн асуудал: Нэг сэдэвт бүтээл** / Ред. Н.Батнасан, Б.Сайнжаргал.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2017.- 106х.- ISBN 0-590-85549-5.

Бизнесийн байгууллагын санхүүжих хэлбэр олон төрөл бөгөөд үүний нэг нь бонд гарган санхүүжих үйл явц юм. Бондын зэрэглэл нь санхүүжигч талын төлбөрийн чадварт суурилсан санхүүгийн үүрэг хариуцлагыг нь тооцоолж буй хэлбэр бөгөөд зохиогч энэ номондоо Монгол улсын компанийн бондын хөгжлийн чиг хандлага, компанийн бондын талаарх зөвлөмж, аргачлал, бондын зээлжих зэрэглэл тогтоох зэргийг тусгажээ.

65.262.2

Л-13

/НУН унш-4, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28125-28127

Баяртсайхан Н. **Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөө дээдэлье** / Ред. Б.Өвгөнхүү; Эмхт. Т.Тэлмэн.- УБ.: Адмон, 2018.- 259х.- ISBN 978-99978-2-058-7.



Энэхүү товхимолд Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханы сонин, сэтгүүл, телевизэд өгсөн ярилцлага болон хэлсэн үг, мэндчилгээ, түүний бичсэн илтгэл, судалгааны өгүүлэл, нийтлэл багтжээ. Мөн Монголбанкны Эрдэнэсийн сангийн музейн дээжээс хавсаргасан байна.

65.262.6

Б-38

/НУН унш-2ш/

ЭШФ Т-20997-20999



Ганзориг А., Батсайхан Д. **Төслийн удирдлага 1: Жижиг дунд бизнесийн төслийн үндэс** / Хян. Дэ.Моломжамц, До.Моломжамц.- УБ., [2017].- 328х.- ISBN 978-99973-2-397-1.

Энэхүү бүтээлд хөрөнгө оруулалтын төслийн техник-эдийн засгийн үндэслэл бэлтгэх, үнэлэхтэй холбоотой арга зүйг шинээр баяжуулах, өөрийн орны зах зээлийн нөхцөлд зохицуулах, төслийн үр ашгийн үнэлгээг оновчтой сонгох, хөрөнгө оруулалтын төсөлд үр ашгийн шинжилгээ хийх,

шийдэл гаргах арга зүй, орчин үеийн төслийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц, аргыг авч үзлээ.

65.290-2

Г-22

ЭШФ Т-20611-20612

Эрдэнэбаяр Ө., Ганбаатар Э. **Эдийн засгийн хөгжлийн “Монгол” загвар** / Ред. М.Бизаагундаа.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 72х.- ISBN 978-99978-1-154-7.



Судлаач Ө.Эрдэнэбаяр энэхүү бүтээлдээ газрын харилцааны хүчин зүйлийн нөлөөллийг шинжилж, газрын үнэлгээний өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодорхойлж эдийн засгийн өсөлт, хөгжлийг хангахад газрын үнэлгээний гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг олон талаас нь авч үзсэн байна. Тус бүтээл нь газрын харилцааны салбарт ажиллагсад, тухайн асуудлаар төрийн бодлого боловсруулагчид, хөрөнгийн мэргэшсэн үнэлгээчид, эрдэм шинжилгээний ажилтнууд, бизнес эрхлэгчид, их дээд сургуулийн багш оюутнууд болон сонирхсон хэн бүхэнд зориулагджээ.

65.32-5

Э-73

/ОУХНУС-2ш/

## УЛС ТӨР, УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН



Өлзийсайхан Ч., Ундрах Д. **Улс төр судлал** / Ред. Г.Цэнд-Аюуш.- УБ.: Арвай Бархан, 2018.- 184х.- ISBN 978-99978-2-729-6.


Өнөө үед улс орны хөгжлийн түвшин, гадаад улс орнуудын улс төрийн хөгжлийн үлгэр жишээг өөрийн орны онцлог байдалтай уялдаа холбоотой авч үзэх шаардлага аяндаа гарч ирж байна. Энэ нь иргэдийг улс төрийн боловсролтой болгох шаардлага урган гарч байгаа бөгөөд улс төрийн боловсрол нь иргэдийг нийгмийн амьдралд аз туршсан байдлаар хандахаас сэргийлж, ингэснээрээ тиран, тоталитари гэх мэт дарангуйлагч улс төрийн байгуулал тогтохоос сэргийлэх боломжтой болгодог ажээ. Энэхүү бүтээлийг их дээд сургуулийн оюутан суралцагсад болон улс төр сонирхогчидод зориулж байна.

66.1

Ө-741

ЭШФ Т-21524-21525

Өлзийсайхан Ч. **Улс төр судлалын салбарт суралцагчдад зориулсан сургалтын материал** / Ред. Д.Ундрах.- УБ.: Арвай Бархан, 2018.- 160х.- ISBN 978-99978-2-730-2.



Энэхүү сурах бичигт улс төрийн шинжлэх ухааны судлах зүйл, үүсэл хөгжил, улс төрийн намуудын үзэл баримтлал, олон улсын харилцааны онол, олон улсын харилцааны систем, улс төрийн эдийн засгийн ухаан, улс төр эдийн засгийн ухааны сонгодог төлөөлөгчид гэсэн сэдвүүдийг авч үзжээ. Уг бүтээл нь улс төр судлалаар суралцаж буй оюутнуудад зориулагджээ.

66.1я73

Ө-741

ЭШФ Т-21526-21527



Хатанболд О. **Ардчилал судлал**: Онол, арга зүй / Ред. Г.Чулуунбаатар, Д.Ганбат, Ц.Цэцэнбилэг.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 179х.- (ШУА. Философийн хүрээлэн).- ISBN 978-99978-4-043-1.

Ардчилал нийгмийн аль ч бүлгийнхэнд, мөн ямар ч түвшний хүмүүст аз жаргалынхаа төлөө тэмцэх, амь зуух, эрх чөлөөгөө эдлэх итгэл найдвар өгөх учиртай. Энэхүү бүтээлийн шинэлэг тал нь орчин үеийн ардчиллын суурь онолуудын хүрээнд дэвшигдэж буй “ард түмний засаглах дээд эрх мэдэл”-ийн тухай концепци, иргэдийн амьдрал дахь ардчиллын төрөлхийн үнэ цэнийн тухай үндэслэл, улс төрийн шийдвэрт ардчилал инструментал болон конструктив учир холбогдолтой болох үзэл санааг Монголын ардчиллын үнэлгээний онол, арга зүйн суурь болгох арга замыг нарийвчилсан онолын логик матриксыг боловсруулан гаргаж Монголын ардчиллыг үнэлж, үр дүнг тодруулах оролдлого хийснээрээ онцлог юм.

66.1

Х-26

/ОУХНУС-2ш/

Брүүк Я., Ваткинс Д. **Чөлөөт зах зээлийн хувьсгал**: Айн Рандын үзэл санаа данхар төрийг төгсгөл болгох нь / Орч. Т.Ариунсанаа; Ред. Б.Болдбаатар.- УБ.: Нэпко, 2017.- 255х.- ISBN 978-99978-51-27-7.



Орос гаралтай Америк зохиолч Айн Рандын хүрээлэнгээс эрхлэн гаргасан АНУ-ын бэстсэллэр болсон энэхүү бүтээл нь данхар төртэй тэмцэх зааварчилгаа юм. Энэхүү номоос чөлөөт зах зээл гэж юу болох, уг зүйл хэрхэн ажилладаг, бас тэгээд яагаад уг үндсээсээ ёс суртахуунтай ёс зүйтэй болохыг мэдэж авах юм. Мөн өнөөгийн бидний амьдарч буй цаг үед төр хэрхэн данхайж буйтай тэмцэх үзэл санааны зэвсэг, ёс суртахууны илүү давуу байр суурь олох болно.

66.2

Б-685

/НУН унш-4ш, ГНОФ-4ш/

ЭШФ Т-21421-21423



Хатанболд О. **Ардчиллыг ойлгохуй ба судлахуй**: Монголын жишээн дээр / Ред. Г.Чулуунбаатар, Ц.Цэцэнбилэг, Д.Ганбат.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 170х.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Философийн Хүрээлэн).- ISBN 978-99978-0-508-9.

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор О.Хатанболд Монголын нийгмийн өөрчлөлтийн сонирхолтой мөртлөө ээдрээтэй асуудал болох ардчилал, ардчиллын төлөвшил, түүнд гарсан өөрчлөлтийг сонгон судалжээ. Зохиогч ардчиллын тухай монголчуудын ойлголтын агуулга тодорхой бодит кейс дээр хэрхэн хэрэгжиж буйг болон Монгол дахь ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлог, тэлгээрийн талаарх иргэдийн ойлголт төсөөлөл, үзэл баримтлалын талаар томоохон судалгаан дээр тулгуурлан энэхүү бүтээлээ туурвижээ.

66.3(1)

X-269

/НУН унш-5ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21364-21368

**Монгол улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо** / Ред. Д.Баасансүрэн.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 299х.- (Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи. Философийн Хүрээлэн. Улс төр судаллын салбар).- ISBN 978-99978-844-2-8.



Энэхүү хамтын бүтээл нь Монгол улс дахь төлөөллийн ба шууд ардчилал, иргэдийн улс төрийн оролцооны харилцан хамаарал, төлөөллийн ба шууд ардчиллыг илүү үр дүнтэй ашиглах арга зам, нөхцөлийг судлан тогтоох, иргэдийн улс төрийн оролцооны арга зам, хэлбэр, загварын зохистой хувилбарыг тодруулах, Монгол улс дахь төлөөллийн ба шууд ардчиллын хэтийн төлөв хандлагыг тодорхойлсон нь ач холбогдолтой болжээ.

66.3(1)6

M-692

/НУН унш-5ш/

ЭШФ Т-21379-21381




Шатар Ё. **Он жилүүдийн тэртээгээс:** Дурсамж, дурдатгал / Хян. Ш.Энхбаяр, Н.Сүрэндаваа.- УБ.: Голден легион, 2017.- 204х.

Энэхүү дурсамж, дурдатгалд Манжийн бэрхшээлийн үеийн болон олноо өргөгдсөн Монгол улсын Түшээт хан аймгийн Мэргэн вангийн хошуу, Ардын засгийн үеийн Богд хан уулын Их дулаан уулын хошуу, одоогийн Сайншанд хотын уугуул иргэн Ёндонгийн Шатар өөрийн болон эцэг эх, хамаатан сандан, ах дүүсийн намтар, түүхийг хүүрнэжээ.

66.3(1)8  
Ш-332

ЭШФ Б-28340-28341

Булаг Э. **Хамтач үндэсний үзэл:** Хятадын Монгол хязгаар дахь найрамдлын бодлого / Хян. Г.Мөнх-Эрдэнэ, Г.Баттогтох.- 2 дахь хэвл.- УБ.: МУИС Пресс, 2017.- 310х.- ISBN 978-99973-77-69-2.



Энэхүү номд Өвөр Монголын тухай голчлон өгүүлэх бөгөөд Монголчуудын үндэсний үзлийн онцлог буюу "хамтач үндэсний үзэл"-ийн талаар тусгажээ. Мөн Монгол Төвд зэрэг үндэсний цөөнхийг бачууртал нь тэвэрсэн "Хятадын ойртон дотнослын соёл"-ыг судалжээ. Онолын хувьд олонх цөөнхийн харилцааны тухай хуучин үзэл баримтлалыг няцаан, гуравдагч талын орон зай бүхий нийгэм гэсэн ойлголтыг дэвшүүлж байна. Энэ бол хятадыг ойлгоход төдийгүй Хятадыг нэгдэл гэхээс гадна хамтын ажиллагаа, зөрчил тэмцлийн талбар гэж харахад тун чухал судалгаа болсон байна.

66.4  
Б-720

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21427-21431



**Монгол-Кубын харилцаа:** Өнгөрсөн, өнөө, ирээдүй / Эмхт. Ц.Батбаяр; Хян. Г.Эрдэнэ.- УБ.: Адмон принт, 2017.- 176х.- ISBN 978-99978-1-227-8.

Монгол Улс, Бүгд Найрамдах Куба Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ой, харилцан бие биеийн нийслэлд ЭСЯ-аа нээсний 55 жилийн ойг тэмдэглэх хүрээнд хоёр улсын харилцааны баримтат түүхийг өгүүлсэн анхны ном хэвлэгдэн гарч байна. Тус номонд Монгол-Кубын харилцааны нэгэн жарны түүхийн хуудсууд, харилцааны өнөөгийн шат, ойрын ирээдүйн тухай архивын баримт ашиглан өгүүлсэн нь Монголын гадаад харилцааг сонирхогч хүн бүхэнд ач холбогдолтой болжээ.

66.4(1)  
М-692

/НУН унш-5ш/

ЭШФ Т-21446-21500



**XX зууны Монгол:** Түүх, соёл, геополитик, гадаад харилцааны тулгамдсан асуудлууд / Ред. С.Чулуун, С.Баттулга; Эмхт. хян. Г.Мягмарсамбуу.- УБ.: Адмон принт, 2017.- 394х.- ISBN 978-99978-1-742-6.




Тус эмхэтгэлд Түүхийн шинжлэх ухааны доктор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин Харгана овогт Цэдэндамбын Батбаярын 60 насны ойд зориулан Монгол, ОХУ, БНХАУ, Япон, АНУ, Канад, Австрели, Энэтхэг, Тайваний 20 орчим эрдэмтдийн Монголын XX зууны түүх, соёл, улс төр, эдийн засаг, гадаад харилцааны сэдвээр бичиж ирүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд багтжээ. Энэхүү товхимол нь Монголын түүх, геополитик, гадаад харилцаа сонирхогч хүн бүхэнд зориулагджээ.

66.4(1)

X-495

/НУН унш-6ш/

ЭШФ Т-21454-21458



Ундрах Д. **Албан харилцааны соёл, ур чадвар** / Ред.Ч.Өлзийсайхан.- УБ.: Арвай Бархан, 2018.- 137х.- ISBN 978-99978-2-731-9.

Олон улсын харилцаа, улс төр судлалын мэргэжлээр суралцагч оюутнуудад зориулсан энэхүү номыг уншиж судалснаар улс төр, олон улсын харилцааны онол, түүхийг үзэж судлахын зэрэгцээ дипломат ёс горим, ёслолын нарийн дэг журам, ажил хэргээ амжилттай хөтлөн явуулах, хэрхэн алдар нэр, амжилт ололтын оргил өөд өгсөх болон харилцааны соёл,

харилцах урлагт суралцах ажээ.

66.49

У-369

ЭШФ Т-21528-21532

**Залуучууд судлал-2017:** Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл.- УБ.: “Хүслийн түүчээ” ХХК., 2017.- 198х.



Монголын залуучуудын холбооноос залуучуудын өмнө тулгараад байгаа олон асуудлыг шийдвэрлэх гарцыг тодорхойлох, оюунлаг залуучуудын онолын мэдлэгээ хөгжүүлэх, бүтээлч сэтгэлгээг өрнүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд энэхүү онол практикийн хуралд тавьсан 6 сэдэв 35 илтгэлийг эмхэтгэн хүргэж байна.

66.75

З-236

ЭШФ Т-21490-21491

## ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН



**Судалгааны эмхэтгэл:** XXV боть / Эмхт. Д.Жигваагүнсэл; Хян. Б.Эрдэнэбилэгт, Ц.Норовдондог.- УБ.: УИХ-ын ТГ-ын хэвлэх, 2017.- 478х.

Тус судалгааны эмхэтгэлд өөр хоорондоо уялдаа бүхий 6 бүлэг асуудлыг тусгажээ. Судалгаанд баялгийг дахин хуваарилалтанд оруулж баян хоосны ялгааг арилгах, монополь компаниудыг хувьцаат компани болгон өөрчлөх арга зам, олон улсын туршлага, давуу болон сул тал, Монгол улсын монополь зах зээл эзэмшигчдийг задлан хувьцаат компани болгон өөрчлөх боломж, түүний давуу болон сул тал, хууль эрх зүйн орчин зэрэг асуудлуудын хүрээнд олон улсын байгууллагуудаас гаргасан судалгааны тайлан, мэргэшсэн судлаач, экспертүүдийн асуудал дэвшүүлсэн нийтлэлүүдийг ашигласан байна.

67.0

C-701

/НУН унш-2ш/

ЭШФ Т-21518-21520

**Судалгааны эмхэтгэл:** XXVI боть / Эмхт. Д.Жигваагүнсэл; Хян. Б.Эрдэнэбилэгт, Ц.Норовдондог.- УБ.: УИХ-ын ТГ-ын хэвлэх, 2018.- 360х.



Энэхүү судалгаанд зээлийн хүүгийн хувийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж буй улс орнуудын хууль эрх зүйн орчныг судалжээ. Үүнд мөнгө хүүлэлтийн эсрэг эрх зүйн зохицуулалт, зээлийн хүүгийн дээд хэмжээг тогтоосон байдал, хариуцлага тооцох механизм зэргийг Европын холбооны гишүүн орнуудын хүрээнд нарийвчлан судалсан байна.

67.0

C-701

/НУН унш-2ш/

ЭШФ Т-21521-21523



**Чимид Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал** / Эрхл. Ч.Батцогт, Ч.Сайнзаяа, Ч.Сайнсанаа; Хян. Ж.Амарсанаа.- 2 дахь хэвл.- УБ., 2017.- 486х.- (Чимид сан).- ISBN 978-99929-68-91-8.

Энэхүү бүтээлд Монгол улсын гавьяат хуульч, хууль зүйн доктор, профессор Б.Чимидийн сүүлийн 10 гаруй жилийн бүтээл хамрагджээ. Тус бүтээлийг Нийтлэг асуудал, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага гэсэн үндсэн 3 дэвтэр, 7 хэсэгтэйгээр эмхэтгэн гаргаж байгаа нь Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй судлалд үнэт зүйл төдийгүй улс төр судлал болон нийгэм судлалын бусад салбар шинжлэх ухаанд чухал ач холбогдолтой болжээ.

67.400.1

Ч-62

/ОУХНУС-3ш, ХЗС-3ш/

Бурмаа Н. **Төрийн хяналт, хариуцлага.**- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 390х.- (Монгол Улсын Их Сургууль. Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль).- ISBN 978-99978-2-371-7.



Энэхүү бүтээл нь хяналт, хариуцлага гэсэн хоёр үндсэн хэсэгтэй. Зохиогч уг бүтээлээрээ хяналт, хариуцлагын ойлголт, ухагдахууныг тайлбарлан хүргэхийн зэрэгцээ чөлөөтэй сэтгэх, харьцуулах, юмс үзэгдлийн учир холбогдлыг гүнзгийрүүлэн ухаарах, эрэл хийх, цаашид судлах зарим асуудлыг дэвшүүлжээ.

67.401я73

Б-769

/НУН унш-5ш/

ЭШФ Т-21508-21512



**“Иргэний эрх зүй-тулгамдсан асуудал, шинэчлэл” сэдэвт илтгэлийн уралдаанаас шалгарсан шилдэг 10 бүтээл-I** / Хян. Э.Золзаяа, Н.Хишигзаяа.- УБ., 2017.- 104х.- (Монголын хуульчдын холбоо. Иргэний эрх зүйн хороо).

Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хороо нь хувийн эрх зүй буюу иргэний эрх зүйн чиглэлийн хуульчдыг эгнээндээ нэгтгэдэг бөгөөд ирээдүйн хуульчдын судалгааны ажлын идэвхийг дэмжих, өнөө цагийн иргэний эрх зүйн судалгааны цар хүрээг тодорхойлоход хувь нэмэр болох үүднээс 2016 оноос эхлэн хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд судалгаа, эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг зохион байгуулдаг бөгөөд тус илтгэлийн уралдаанаас шалгарсан 10 бүтээлийг энэхүү эмхэтгэлд нийтэлжээ.

67.404

И-788

/ХЗС-1ш/

**“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал, шинэчлэл” сэдэвт илтгэлийн уралдаанаас шалгарсан 10 шилдэг бүтээл-II** / Хян. Н.Хишигзаяа.- УБ., 2017.- 108х.- (Монголын хуульчдын холбоо. Иргэний эрх зүйн хороо).



Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хороо нь хувийн эрх зүйг сонирхон судалж буй оюутан, судлаачдыг дэмжих, ирээдүйн хуульчдын залгамж холбоог бэлтгэх, онол практикийн мэдээлэл солилцох зорилгоор оюутнуудын дунд илтгэлийн уралдааныг хоёр дахь жилдээ зохион байгууллаа. Тус илтгэлийн уралдаанд 30 илтгэл ирсэнээс уралдаанд шалгарсан 10 илтгэлийг эмхэтгэн хүргэж байна.

67.404

И-788

/ХЗС-1ш/



Оюунаа Ц. **Өв залгамжлалын эрх зүй**: Олон улсын хувийн эрх зүйн хүрээн дэх судалгаа / Ред. Ж.Амарсанаа.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 242х.- ISBN 978-99978-0-829-5.

Өв залгамжлал бол иргэний эрх зүйн эрт дээр үеийн институтийн нэг бөгөөд түүний хэм хэмжээнүүд нь өөд болсон этгээдийн эдийн эрх болон үүрэг нь эрх зүйн өөр субъектэд шилжих талаарх харилцааг зохицуулдаг ажээ. Уг бүтээл нь 8 бүлэгтэй, бүлэг тус бүр 4-10 дэд сэдэвтэй, нэр томьёоны дэлгэрэнгүй ишлэл зүүлт, хураангуй нэр томьёо, Олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, гадаад орнуудын хуулийн сайт, ном зүй гэсэн бүтэцтэй бөгөөд өв залгамжлалын харилцааны тухай сонирхогч хэн бүхэнд зориулагджээ.

67.404.5

О-63

/НУН унш-4, ГНОФ-3, ХЗС-10ш/ ЭШФ Б-28102-28104

Улаанбаатар Б. **Монгол улс дахь гэрээслэл**: Асуудал, шинэчлэлт (Тулгуур асуудал, уламжлал, шинэчлэл) / Ред. С.Нарангэрэл, Т.Мөнхжаргал.- УБ., 2017.- 180х.- ISBN 978-99978-2-049-5.



Зохиогч уг бүтээлдээ Монгол улсад өв залгамжлал түүний дотор гэрээслэлтэй холбогдсон хууль тогтоомжийг шинэчлэх зайлшгүй шаардлага тулгарч байгааг үндэслэн энэ талаарх үзэл баримтлалаа боловсруулан дэвшүүлсэн байна. Энэхүү бүтээлдээ Монголын иргэний эрх зүй судлал түүний бие даасан институт болох өв залгамжлалын эрх зүй ялангуяа гэрээслэлийн хууль зүйн онол-практикийн асуудлыг авч үзжээ.

67.404.5(1)

У-295

/ХЗС-1ш/



**Хот дахин төлөвлөлт-газар чөлөөлөлт-хүний эрх**: Онол, практикийн бага хурлын илтгэл, зөвлөмж.- УБ., 2017.- 102х.


2017 оны 5 дугаар сарын 19-ний өдөр “Хот дахин төлөвлөлт-газар чөлөөлөлт-хүний эрх” онол, практикийн бага хурал зохион байгуулагдсан бөгөөд тус хурлаар хот, суурин газрыг дахин хөгжүүлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд Монгол улсын үндсэн хуулиар баталгаажсан газар болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, шаардлагад нийцсэн орон байраар хангагдах зэрэг хүний үндсэн эрхүүдийн мөн чанарыг ойлгож буй эсэх, хэрэгжүүлэлт, зохион байгуулалт, маргаан шийдвэрлэх талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хөнджээ.

67.407+85.118

Х-505

/ХЗС-1ш/

Баярсайхан Д. **Эрүүгийн процессын албадлага ба хүний эрх.**- УБ.: Нью Индиго, 2018.- 136х.- (МУИС-ийн Хууль зүйн сургууль).- ISBN 978-99978-2-304-5.



Уг бүтээлд эрүүгийн процесс дахь хүний эрхийн асуудалд онол практикийн дүн шинжилгээ хийх замаар үндэслэл бүхий дүгнэлт хийжээ. Энэхүү бүтээлийг эрүүгийн процессын албадлага ба хүний эрхийн чиглэлээр ажилладаг хуульч, судлаач, өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгч, магистрант, докторант болон уг асуудлыг сонирхогч нарт зориулав.

67.411

Б-381

/ХЗС-10ш/



Байгаль Э. **Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй.**- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 228х.- ISBN 978-99978-0-935-3.

Энэхүү бүтээлд Э.Байгаль нь сүүлийн жилүүдэд олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн чиглэлээр хийсэн судалгааны ажлаа эмхэтгэжээ. Мөн олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүйн үндсэн асуудал, зарчим, хөрөнгө оруулалтын гэрээний төрөл, ангилал, хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхтэй холбогдон үүсэх эрх зүйн асуудлыг хөндсөн нь хууль зүйн чиглэлээр суралцагчид болон хуульч, судлаач, түүнчлэн шийдвэр гаргах түвшинд ч хэрэглэгдэхээр ач холбогдолтой болжээ.

67.412

Б-174

/ХЗС-5ш/

**Олон улсын хувийн эрх зүй:** Баримт бичгийн эмхтгэл / Ред. Ж.Амарсанаа; Эмхт. Э.Байгал, Т.Замбага.- 4 дэх хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 784х.- ISBN 978-99978-1-858-4.



Сүүлийн жилүүдэд олон улсын хувийн эрх зүй, олон улсын бизнесийн эрх зүйн харилцаанд Монгол улсын иргэн, хуулийн этгээд чөлөөтэй оролцох болсноор эдгээр харилцаанд холбогдох үндэсний хууль тогтоомжоос гадна олон улсын эрх зүйн эх сурвалжийг судлах, хэрэглэх зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарч байна. Энэхүү эмхтгэл нь олон улсын гэрээ, Монгол улсын хууль гэсэн үндсэн 2 хэсэгтэй бөгөөд олон улсын бизнесийн эрх зүй судлаач багш нар болон шүүгч, арбитрчид, өмгөөлөгч, хууль зүйн зөвлөх, бизнес эрхлэгчид, төрийн албан хаагчид болон хувь иргэд ч ашиглах боломжтой юм.

67.412.2

О-259

/НУН унш-3ш, ХЗС-10ш/

ЭШФ Т-21392-21393





**Монгол улсад 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал:** Албан хэрэгцээнд / Хян. О.Зоригт, П.Батбаатар.- УБ., 2018.- 239х.


Энэхүү товхимолд Монгол улсын хэмжээнд 2017 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээг боловсруулан үзүүлэлтүүдийг нийслэл, дүүргүүд, орон нутгаар задлан харуулжээ. Мөн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, гэмт хэргийн онцлог, шалтгаан, гэмт хэрэгт холбогдсон хүний онцлог, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийг оруулсан нь хуулийн чиглэлээр суралцагсад болон судлаачдад гарын авлага болох ач холбогдолтой юм.

67.51(1)

М-692

/ХЗС-1ш/

**Баяр Б. Криминалистик** / Ред. Д.Баярсайхан.- УБ.: Үсэг хоршоо, 2017.- 394х.- ISBN 978-99973-930-6-7.




МУИС-ийн Хууль зүйн сургуулийн нийтийн эрх зүйн тэнхмийн багш доктрант Б.Баярын энэхүү ном нь Монгол улсын криминалистикийн шинжлэх ухааны уламжлалт хандлагыг улам баяжуулснаас гадна орчин үеийн техник, технологи, арга зүйн шинэ ололт, үр дүнг бүтээлчээр тусгаснаараа шинэлэг бүтээл болжээ. Ялангуяа гэмт хэргийг олж тогтоох, гэмт этгээдийг илрүүлэхэд чиглэгдсэн мөр судлалын арга, техникийг нэлээд цогц байдлаар авч үзсэний зэрэгцээ криминалистикийн техникийн үндсэн төрлүүдийг практик хэрэглээтэй уялдуулж тайлбарласан нь шинжлэх ухааны үндэслэлтэй, практик ач холбогдолтой болсон нь зөвхөн оюутан суралцагсад төдийгүй хууль сахиулах байгууллагын ажилтнуудад ч сургалтын чухал хэрэглэгдэхүүн болохоор ач холбогдолтой ажээ.

67.52

Б-38

/ХЗС-10ш/

Цахим номын сан-22



**Монгол улсын шүүхийн тайлан: 2017 он** / Эмхт. Ж.Сайнхишиг, Б.Отгон; Хян. Н.Лүндэндорж, Т.Мэндсайхан, Ц.Мандах.- УБ.: Адмон принт, 2018.- 275х.

Энэхүү товхимолд Шүүхийн захиргааны тухай хуулийн 18-р зүйлийн 18.1.8, 18.1.9-д заасныг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны болон шүүн таслах ажиллагааны 2017 оны тайланг бүрэн эхээр нь эмхэтгэн оруулжээ.

67.71(1)

М-692

/ХЗС-1ш/

ЭШФ Т-21476-21477

**Өмгөөлөл судлал:** Боть-2: Шинэтгэлийн асуудалд / Эмхт. З.Сүхбаатар, П.Оюундэлгэр.- УБ.: Адмон принт, 2017.- 312х.- (Өмгөөлөл судлалын академи, “Монгол өмгөөлөгч” Хууль зүйн фирм).- ISBN 978-99978-0-524-9.



Өмгөөлөлд хамааралтай нэр томъёо судлалын талаар, гадаад орнуудын өмгөөлөгчдийн эрх зүйн орчинг Монголын эрх зүйн орчинтой харьцуулсан судалгаанд дүгнэлт хийж, ялангуяа өмгөөллийг тойрсон эрх зүйн шинэтгэлийн талаар нийтлэгдсэн өгүүлэл, судалгаа шинжилгээний сонирхол татсан бүтээлүүдийг эмхтгэн хэвлүүлжээ.

67.75

Ө-762

ЭШФ Т-20587-20588



**Гадаад орнуудын өмгөөлөгчийн тухай хууль I** / Ред. З.Сүхбаатар, П.Оюундэлгэр.- УБ.: Адмон принт, 2017.- 284х.- (“Монгол өмгөөлөгч” Хууль зүйн фирм, Өмгөөлөл судлалын академи).- ISBN 978-99929-2-832-5.

Хууль зүйн мэргэжлийн туслалцааны илэрхийлэл болох өмгөөллийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, цаашид шинэтгэлийг гүнзгийрүүлэхэд туслах зорилгоор гадаадын зарим улс орнуудын өмгөөлөгчийн тухай хуулиудыг орчуулан нийтийн хүртээл

болгохоор хэвлэн гаргажээ.

67.75(0)

Г-13

T-20595-20596

## ШИНЖЛЭХ УХААН. ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

**Acta historica:** Боть-18 / Эрхл. Л.Алтанзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 228х.- (Монгол Улсын Боловсролын Их Сургууль).- ISSN 2311-1461.



МУБИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт угсаатан судлал, сурвалж судлал, монголын эрт, дундад үеийн түүх, ойрхи үеийн түүхэнд холбогдох судалгааны өгүүлэл, илтгэлүүд оржээ.

72+63

A-19

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21023-221025



**Гадаад хэл соёл судлал:** Эрдэм шинжилгээний бичиг: Боть-467(21) / Эрхл. Д.Сайнбилэгт.- УБ.: МУИС-ийн хэвлэл, 2017.- 216х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх Ухааны Сургууль).- ISSN 2306-3904.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбараас эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээ, судалгааны энэхүү бичигт эрдэмтэн, судлаачдын гадаад хэл шинжлэл, гадаад хэлний боловсрол, орчуулгазүй, соёл судлал зэрэг асуудлуудыг хөндсөн өгүүлүүд багтжээ.

72+81

Г-132

/НУН унш-2ш, Лав-1ш/

ЭШФ Т-21318-21319

**Газарзүйн асуудлууд=Journal of Geographic issues:** ЭШБ, МУИС, 2017, №17(1).- УБ., 2017.- 69х.- (Монгол Улсын Их Сургууль).- ISSN 2312-8534.


МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулиас эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний бүтээлийн цувралын энэ дугаарт аялал жуулчлал, газар зохион байгуулалт, төвийн бүсийн дотоод бүсчлэл, банкны салбарын орон зайн загварчлал зэрэг сэдвээр хийсэн эрдэмтэн, судлаачдын судалгааны өгүүлэл, илтгэлүүд хэвлэгджээ.

72+26.89

Г-16

/Лав-1ш/

ЭШФ Т-21008



**МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг:** Физик №24(486) / Эмхт. Г.Эрдэнэ-Очир; Ред. Х.Цоохүү.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2017.- 76х.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Физикийн тэнхимээс эрхлэн гаргадаг удаагийн эрдэм шинжилгээний бүтээлийн цувралын энэ дугаарт эрдэмтэн судлаачдын судалгааны ажлууд болон тэдгээрийн үр дүн, дүгнэлтийг эмхэтгэн та бүхний гарт хүргэж байна.

72

М-692

/БУН унш-2ш, Лав-1ш/

ЭШФ Т-19305-19306

**МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг:** Физик. ЭШБ, МУИС, 2017, №25(478).- УБ., 2017.- 221х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх Ухааны Сургууль).- ISSN 2311-1097.

МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулиас эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний бүтээлийн цувралын энэ дугаарт “Физик, физикийн боловсролын асуудлууд” эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн эрдэмтэн, судлаачдын 23 судалгааны өгүүлэл, илтгэл хэвлэгджээ.

72+22.3

М-692

/БУН унш-2ш, Лав-1ш/

ЭШФ Т-21005-21006



**Монгол судлал:** Эрдэм шинжилгээний бичиг: Боть-XLI(483) / Эрхл. Б.Түвшинтөгс.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 217х.- (Монгол Улсын Их Сургууль).- ISSN 1997-1826.

МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулиас эрхлэн хэвлүүлдэг “Монгол судлал” эрдэм шинжилгээний цувралын энэ удаагийн дугаарт МУИС-ийн монгол хэл, хэл шинжлэл, утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш

нарын эрдэм шинжилгээний бүтээлүүдээс гадна гадаадын зарим их дээд сургууль, байгууллагын судлаачдын бүтээлүүдийг багтаажээ.

72+80

M-692

/НУН унш-2ш, Лав-1ш/

ЭШФ Т-21322-21323

**Эрдэм шинжилгээний бичиг:** №9(482) / Эмхт. О.Нандин-Эрдэнэ, Л.Золжаргал; Ред. Т.Энх-Амгалан, Л.Оюун, Л.Мөнх-Очир ба бус.- УБ.: МУИС Пресс, 2018.- 621х.- (Монгол Улсын Их Сургууль. Эрдэнэт сургууль).- ISBN 978-99973-4-269-0.



МУИС-ийн Эрдэнэт сургууль үүсэн байгуулагдсаны 25 жилийн ойд зориулан “Орон нутгийн хөгжилд нийгэм, хүмүүнлэг, эдийн засгийн салбарын судлаачдын оролцоо” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан билээ. Эрдэм шинжилгээний бичиг сэтгүүлийн энэхүү тусгай дугаарт эдийн засаг, бизнесийн удирдлага, хэл соёл, боловсрол судлал зэрэг сэдвээр эрдэмтэн багш, судлаачдын хуралд хэлэлцүүлсэн илтгэлүүдийг эмхэтгэн хүргэж байна.

72

Э-739

/Лав-1ш/

ЭШФ Т-21485-21487



**Эрдэм шинжилгээний бичиг:** Түүх XV №474(36), 2016 / Эрхл. П.Дэлгэржаргал, Э.Жигмэддорж.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 198х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх Ухааны Сургууль. Хүмүүнлэгийн ухааны салбар).- ISSN 2224-1804.

МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбараас эрхлэн гаргадаг “Historia Mongolarum” эрдэм шинжилгээний бичигт нийт 12 багш, эрдэмтдийн судалгааны өгүүлэл, орчуулга оржээ. Үүнд Б.Батжаргалын “Хань улсын цэргийн агтны төлөөх дайн”, Э.Жигмэддоржийн “Халхын үйсэн цааз” дахь ноёдын удам угсааг тодруулах асуудалд, Б.Эрдэнэбилэгийн “ЗХУ, БНМАУ дахь олзлогдсон Япон цэргүүдийн асуудал (1945-1946)” зэрэг сонирхолтой өгүүллүүд багтсан байна.


72+63

Э-739

/НУН унш-3ш, Лав-1ш/

ЭШФ Т-21488-21489

**Эрдэм шинжилгээний бичиг:** Сэтгүүл зүй: 2017 №18(479).- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 300х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх Ухааны Сургууль. Нийгмийн Ухааны Салбар. Сэтгүүл зүй, Олон Нийтийн Харилцааны Тэнхим).- ISSN 2306-4463.



МУИС-ий Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимээс эрхлэн гаргадаг “Сэтгүүл зүй” эрдэм шинжилгээний өгүүллийн энэхүү дугаарыг 2001 оноос хойш тус сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн даргаар ажиллаж байсан доктор, дэд профессор, сэтгүүл зүйн нэрт эрдэмтэн, багш Чойжилжавын

Чойсамба агсаны гэгээн дурсгалд зориулав. Тус сэтгүүлд сэтгүүл зүйн салбарт ажилладаг судлаач, эрдэмтэдийн тавьсан илтгэл, судалгааны бүтээлүүд оржээ.

72+76.01

Э-739

/Лав-1ш/

ЭШФ Т-21063-21065



**Монголын хятад судлал-I** / Эрхл. М.Чимэдцээ, Жу Жүнли.- УБ.: Удам соёл, 2015.- 273х.- (Монгол Улсын Их Сургууль. Күнзийн институт).- ISBN 978-99973-920-0-8.- ISSN 2313-6162.

“Монголын хятад судлал” сэтгүүлийн энэ дугаарт хоёр орны найрамдал, хамтын ажиллагааны хөгжил, Хятадын соёл, түүх, гүн ухаан, Монгол дахь хятад хэлний сургалт, олон улсын хятад хэлний боловсрол зэрэг асуудлаар Монгол, Хятадын эрдэмтэн, судлаачдын бичсэн өгүүллийг нийтэлжээ.

72+81.2Хят

М-695

/НУН унш-5ш/

ЭШФ Т-21278-21282

**Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Зава Дамдин гавж** / Эмхт. Д.Цэрэнсодном.- УБ.: Тод бичиг, 2017.- 259х.- (Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн).- ISBN 978-99978-892-3-2.

Энэхүү бүтээлд Монголын их бандида Зава Дамдин буюу Лувсандаяан ламын товч намтар болон түүний мэндэлсний 150 жилийн ойд зориулсан “Алтан дэвтэр” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлүүд багтжээ. Түүхэн баримт сөхөж үзвээс Дамдин гавж тухайн үеийнхээ Өрнө дахины Дорныг судлагч эрдэмтэдтэй өргөн харилцаатай байжээ.

72+86.2

С-703

ЭШФ Б-28399-28401



**Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Гэлэгжамц дооромбо** / Эмхт. Д.Цэрэнсодном.- УБ.: Тод бичиг, 2017.- 210х.- (Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн).- ISBN 978-99978-892-5-6.

Судар бичгийн хүрээлэнгийн гурван ламаас хамгийн бага судлагдсан нь орчуулагч, эмч, зурхайч, түүхч Гэлэгжамц дооромбо юм. Энэхүү эмхэтгэлд Гэлэгжамц дооромбын орчуулгын зохиолынх нь төлөөлөл болгож Д.Бүрнээгийн “Заяа Памдины зохиосон Хорчойнжүнгийн Үндэс (Зава) номын Гэлэгжамц дооромбын орчуулгын хоёр зүйл эхийн тухай” гэсэн өгүүллийг нийтэлжээ. Мөн Гэлэгжамц дооромбын эмийн гар дэвтрээс монгол эм тангийн жорыг түүвэрлэн оруулжээ.

72+5

С-703

ЭШФ Б-28402-28404



**Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн Шагж гэвш / Эмхт. Д.Цэрэнсодном.- УБ.: Тод бичиг, 2017.- 226х.- (Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн).- ISBN 978-99978-892-2-5.**



Монгол улсын Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн, хэл бичгийн эрдэмтэн Шагжийн 1929 оны үед туурвисан “Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманийн эрих” хэмээх толийг уг эхээс аль болох эвдэхгүйгээр хэвлэн та бүхэнд өргөн барьж байна. Зохиогч эл толь бичигтээ тухайн үеийн бичгийн хэлэнд түгээмэл хэрэглэгдэх 9000 орчим үгийг сонгож эрэхүйеэ хялбар болгон үсгийн дараалалд оруулан нийтлүүлж байжээ.

72+81.2Мон

C-703

ЭШФ Б-28405-28407

### **БОЛОВСРОЛ. СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ШИНЖЛЭХ УХААН**



**Нээлттэй боловсрол 2017:** Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл.- УБ., 2017.- 144х.- ISBN 978-99973-0-845-0.

“Нээлттэй мэдлэг боловсролын сан”-гаас санаачлан зохион байгуулдаг “Нээлттэй боловсрол” эрдэм шинжилгээний уг хурал нь Монгол улсын боловсрол судлал тэр дундаа нээлттэй боловсролыг хөгжүүлэх, судалгааны чиглэлийг тогтоох, судлаачдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг дэмжих зорилготой юм. Уг хуралд ирүүлсэн илтгэлүүдээс судалгааны түвшин, шинжлэх ухаанч арга зүйг ашигласан байдал зэргийг үе шаттайгаар сонгон шалгаруулсан бөгөөд шалгарсан илтгэлүүдийг эмхэтгэн хүргэж байна.

74

H-905

/НУН унш-3ш/

ЭШФ Т-21090-21092

**Нээлттэй боловсрол 2018:** Эрдэм шинжилгээний хурлын өгүүллийн эмхэтгэл.- УБ., 2018.- 112х.- ISBN 978-99973-0-845-0.



МУИС-ийн Математикийн тэнхим болон “Нээлттэй мэдлэг боловсролын сан”-гаас санаачлан “Нээлттэй боловсрол” эрдэм шинжилгээний хурлыг сүүлийн 3 жилд зохион байгуулж байна. Тус хурал нь Монгол улсад боловсрол судлал тэр дундаа нээлттэй боловсролыг хөгжүүлэх, энэ чиглэлээр мэргэшсэн судлаачдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой юм. Энэхүү бүтээлд хоёр үе шаттай хянан магадлагаа хийж, сайжруулсан өгүүлүүдийг эмхэтгэжээ.

74

H-905

/НУН унш-3ш/

ЭШФ Т-21093-21095





Даваа Ж. **Сурган хүмүүжүүлэх зүй** / Хян. Ч.Баямбаханд.- УБ.: Соёмбо принтинг, [2018].- 192х.- ISBN 978-99962-960-8-6.

Энэ номонд хүүхдийн танин мэдэх хэрэгцээ, сурах арга, боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэд, бие хүний хөгжил, төлөвшил, боловсрол, хүмүүжил, тэдгээрийн холбоо хамаарал, эцэг эх, асран хамгаалагчидтай ажиллах арга зүй, багшийн сэтгэл зүйн онцлог, имидж, багшийн ажлын үнэлгээ, багшийн хөгжлийн асуудлыг тусгажээ. Мөн сурган хүмүүжүүлэх зүйн үүсэл, хөгжил, хандлага, сурган хүмүүжүүлэх үйл явц, түүнийг зохион байгуулах асуудал, ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга, арга зүй, сургалтын орчин үеийн загвар зэргийг багтаасан нь багш нар, боловсрол судлалын чиглэлээр сурч буй оюутан, магистр, доктор, дээрх асуудлыг сонирхсон хүн бүхэнд зориулсан байна.

74.0

Д-121

/НУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Б-28467-28469

**Домог болсон Домхүү багш:** Дурсамж, тэмдэглэл / Эмхт. Л.Норовсүрэн; Хян. Д.Энхцэцэг.- УБ.: Адмон, 2017.- 170х.- ISBN 978-99978-2-077-8.



Говь-Алтай аймгийн иргэн Дагванэрлэг овгийн Халтарын Домхүү нь 1929 онд төрж, 1940 онд Тамч сумын бага сургууль, 1944-1947 онд Улаанбаатар хотын Багшийн сургуулийг бага ангийн багш мэргэжлээр төгсчээ. Тэрээр Говь-Алтай аймгийн Хасагжаргалан, Биж-Алтай, Бугат, Тайшир зэрэг сумын хичээлийн эрхлэгч, захирал, Намын үүрийн дарга, хэлтсийн дарга, 1979-1990 онд Улаанбаатар хотын Гурилын комбинатын Намын үүрийн дарга, боловсон хүчний эрхлэгч зэрэг ажил, алба хашиж байжээ. Х.Домхүүгийн гэгээн дурсгалд зориулж энэхүү бүтээлийг өргөн барьж байна.

74(1)

Д-497

ЭШФ Т-21087-21088



Нонна Д. **Монгол улсад сургуулийн өмнөх боловсрол хөгжиж ирсэн нь:** 1921-2000.- УБ.: Ундраг принт, 2014.- 364х.- ISBN 978-99929-9-061-9.

Энэ номонд Монгол улсын сургуулийн өмнөх байгууллагын үүсэл хөгжил ямар ямар түүхэн үе шатыг дамжиж, ямар бэрхшээл зөрчлийг туулж ирсэн түүхэн замналыг өгүүлнэ. Энэхүү түүхэн сэдэвт бүтээлийг Ардын боловсролын яамны архив, түүхийн материалаас, төр засгаас гаргасан тогтоол тушаал зэрэг төрийн баримт бичиг, орон нутгийн боловсролын хэлтсийн материал, ахмад багш нарын дурдатгал зэргийг тулгуурлан бичжээ.

74.1(1)

Н-729

/НУН унш-3ш/

ЭШФ Т-21497-21498

Оюунгоо Б. **Шалгалтын арга хэлбэрүүд**: АШУҮИС-ийн жишээн дээр тулгуурлан бүтээв.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 300х.- ISBN 978-99978-0-647-5.



Энэхүү номын зорилго нь шалгалтын арга, үнэлгээний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, шинэ мэдээллийг түгээн дэлгэрүүлэх юм. Номын 1-р хэсэгт оюутныг үнэлэх шалгалтын арга хэлбэрүүд, зарчим, үнэлгээний ерөнхий утга санаа, нэр томъёоны талаарх ойлголтыг, 2,3,4-р хэсэгт шалгалтын аргуудын давуу болон сул тал, жишээ, зөвлөмжүүдийг оруулжээ. Энэ ном нь анагаахын боловсрол олгодог их дээд сургуулийн багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэхээс гадна бүхий л сургалтын байгууллагын хөтөлбөрийн болон үнэлгээний зөвлөлийн гишүүд, нийт багш, эмч-багш нарт зориулагдсан болно.

74.202.5

О-63

ЭШФ Т-19309-19311



Нямгэрэл Ч. **Олон-сонголтот даалгаврын шинжилгээ**: Их дээд сургууль, ЕБС-ийн багш нарт зориулсан гарын авлага / Хян. Ц.Амартайван.- УБ.: МУИС-ийн хэвлэх, 2018.- 132х.- ISBN 978-99978-2-535-3.

Суралцагчдыг үнэлэх олон арга байдаг бөгөөд өөр өөрийн давуу болон сул талтай юм. МУИС-д зааж байгаа ерөнхий суурийн хичээлүүдийг нэг дор зуугаас олон оюутан судалж байгаагаас оюутныг үнэлэхэд маш их хургацаа зарцуулж байгаатай холбоотойгоор олон-сонголтот даалгаврын хариултыг зөв шинжилж үнэн зөв үнэлгээ хийх боломжийг бий болгох мөн багшийн ажлыг хөнгөвчлөх үүднээс энэхүү гарын авлагыг гаргажээ. Энэ гарын авлага нь их дээд сургуулийн багш төдийгүй олон-сонголтот даалгаврыг үнэлгээндээ хэрэглэдэг ЕБС-ийн багш нар хэрэглэх боломжтой ажээ.

74.202.5

Н-984

/БУН унш-3ш, ГНОФ-4ш/

ЭШФ Т-21505-21507

Урангуа Ж. ба бус. **Түүхийн салбар 70 жилд** / Э.Жигмэддорж, П.Мягмар; Ред. П.Дэлгэржаргал.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 245х.- (Монгол Улсын Их Сургууль. Шинжлэх Ухааны Сургууль. Хүмүүнлэгийн ухааны салбар Түүхийн тэнхим).



1947 онд МУИС-ийн Түүхийн тэнхим байгуулагдаж, дээд боловсролтой түүхч мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 70 жилийн ойд зориулан энэхүү бүтээлийг гаргажээ. Тэр цагаас хойш 57 төгсөлт хийж, үндэсний дээд боловсролтой 1800 гаруй түүхч мэргэжилтэн бэлтгэжээ. Энэхүү бүтээлээс МУИС-ийн түүхийн тэнхимийн үүсэл, хөгжил, түүхийн салбараас төрсөн алдар цолтнууд, эрдэмтэн багш нар болон төгсөгчдийн дурсамжийг унших болно.

74.58(1)

У-458

/НУН унш-2ш, Лав-1ш/

ЭШФ Т-21499-21501

**СЭТГҮҮЛ ЗҮЙ. НОМЫН САН СУДЛАЛ**



Норовсүрэн Л. **“Уриа” сонин**: Судалгаа, нийтлэл / Ред. Н.Ариунзаяа.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 200х.- ISBN 978-99978-0-773-1.

“Уриа” сонин бол МАН, Ардын засгийн албан ёсны анхны сонин юм. Тус сонин 1921.07.19-ны өдрөөс 1922.12.26-ныг хүртэл нийт 21 дугаар гарсан боловч Үндэсний төв архив, МҮНС-д байгаа хураамжийг үзвэл 18 дугаар байх боловч урагдаж, тасарсан байгаа бөгөөд хэдэн жилийн дараа бол бүр үрэгдэж үгүй болох эрсдэл байгааг үгүйсгэх аргагүй тул сонины мэдээллийг эмхтгэж энэхүү гарын авлагыг бэлтгэн МУ-ын шинэ түүх болон, үндэсний сэтгүүл зүйг сонирхогчдод зориулан өргөн барьжээ.

76.02(1)

Н-74

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28105-28107

Норовсүрэн Л. **Монгол туургатны хуучин сонин, сэтгүүлийн ойллого** / Ред. Н.Ариунзаяа.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2017.- 362х.- ISBN 978-99978-1-755-6.




Монгол хүн өөрийн гар, ухаанаар тогтмол хэвлэл гаргаж, үндэсний сэтгүүл зүйн эхлэлийг тавьснаас хойш 113 жил өнгөрч байгаа бол Монгол улс анхны сонингоо гаргаад 105 жил болжээ. Энэ лавламж эмхэтгэлд он жил улирах тусам мартагдаж хуучирсаар байгаа монгол туургатны тогтмол хэвлэл сонин сэтгүүлийн нэр, хэвлэгдсэн хугацаа, тоо хувь, агуулгын үнэ цэнийн талаар мэдээллийг эмхтгэн, 1895-2000 оны хооронд хэвлэгдэж байсан монгол үндэстний 1215 нэрийн сонин, сэтгүүлийн жагсаалтыг хавсаргажээ.

76.02(1)

Н-749

/НУН унш-5, ГНОФ-5/

Б-28108-28110



**МУИС-ийн номын сангийн түүхэн товчоон**: 1942-2017 он / Эмхт. М.Кунай, Ч.Мөнхзул, М.Намжилмаа ба бус.; Ред. О.Нарантуяа, С.Найгалмаа.- УБ.: Бемби сан, 2017.- 312х.- ISBN 978-99978-2-094-5.

Энэхүү бүтээлд МУИС-ийн номын сан үүсэн байгуулагдсан цагаас эдүгээ хүртэлх 75 жилийн түүхэн замналыг архивын материал, дурсамж тэмдэглэл, ном хэвлэлээс түүвэрлэн эмхэтгэсэн болно.


78.33(1)+74.58(1)

М-69

/НУН унш-3ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28099-28101

Дашням Г. ба бус. **Манж, монгол албан бичгийн зарим нэр томъёо, үг хэллэг** / Г.Дашням, Э.Мөнхцэцэг, Да. Эрдэнэбат; Хян. З.Лонжид.- 2 дахь хэвл.- УБ.: Удам соёл, 2017.- 160х.- (Монгол Улс. Архивын Ерөнхий Газар).



Монголын ард түмний оюуны соёлын үнэт өв болсон хуучин харааны баримт бичгийг судлан шинжлэх, уншин танилцахад олон нэр томъёо, үг хэллэг нь өнөө цагт хуучирсан үгийн эгнээнд шилжиж, уншигч судлаачдад бэрхшээл учирч байгаа учир өмнө нь хэвлэгдсэн бүтээлээ нэмэн засварлаж 296 үгийн тайлбарыг эмхэтгэн хэвлүүлжээ.

79.3+81.2М-4

М-22

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28130-28132

### ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН



Сэрчмаа Ш. **Ярианы хэлэнд түгээмэл хэрэглэгддэг англи хэлний өвөрмөц хэлц.**- УБ.: Удам соёл, 2017.- 303х.- ISBN 978-99978-0-161-6.

Энэхүү номоос англи хэлний ярианд түгээмэл хэрэглэгддэг зүйр цэцэн үг, өвөрмөц хэлц, хэвшмэл хэллэг мөн хэлцийн утгын тайлбар, харилцан яриаг жишээ өгүүлбэрүүдээс ойлгох бөгөөд англи хэлийг чөлөөтэй эзэмшин, ярьж сурахыг хүссэн оюутан залуус, судлаач, багш нар болон хэл сурахыг эрмэлзэж байгаа хэн бүхэнд зориулжээ.

81.2Англ-З

С-960

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28418-28419

Эрдэнэчимэг М. **Дани-Монгол Монгол-Дани толь бичиг:** Толь нь дани үгийн хувирал, ярианы энгийн хэллэг агуулна.- УБ., 2006.- 204х.- ISBN 99929-0-811-4.




Тус толь бичиг нь 4200 гаруй Дани-Монгол үг, 3000 гаруй Монгол-Дани үг, харилцан ярианы хэллэг зэргийг багтаажээ. Мөн Дани-Монгол үгийн толийг Дани хэлний цагаан толгойн үсгийн дарааллаар жагсааж, үгсийн аймаг, үгийн хувилбар, дагавар нөхцөл, орчуулга, салаа утга, утга тодруулах жишээг оруулсан байна. Харин Монгол-Дани хэсэгт Монгол хэлний кирилл цагаан толгойн үгсийн дарааллаар жагсааж, үгсийн аймаг, дуудах галиг, үгийг монгол бичгээр бичсэн бичлэг, орчуулга зэргийг оруулжээ.

81.2Дан-4

Э-739

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28478-28479



Дашдондов Ц. **Монгол-Англи өвөрмөц хэлц, хэллэгийн их гарын толь** / Хян. С.Алтанцэцэг.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 1162х.- ISBN 978-99962-3-922-9.

Аливаа хэлэнд тодорхой утга санааг тогтвортой дүрслэлээр илэрхийлсэн өвөрмөц хэлц, хэллэгүүд олон байдаг бөгөөд түүнийг хэл шинжлэлд idiom хэмээн нэрийдсээр иржээ. Сэтгүүлч Ц.Дашдондов Монгол хэлний өвөрмөц хэлц, хэвшмэл үгсийг англи хэлний тохирох хувилбаруудтай дүйлгэн зэрэгцүүлсэн судалгаа хийснийхээ үр дүнд энэхүү толийг эмхэтгэн гаргаж байна. Уг толь бичиг нь англи хэл сурч байгаа монгол хүн, монгол сурч байгаа гадаадынханд чухал гарын авлага болох төдийгүй бие биесийнхээ ахуй амьдрал, зан заншил, хэл соёл, сэтгэхүйн онцлогийг танин мэдэхэд тустай бүтээл болжээ.

81.2М-4

Д-39

/НУН угш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28136-28138

Баттөгс Ш. **Хэрэглээний найруулга зүй ба найруулах эрдэмд суралцах нь**. - УБ.: Бит пресс, 2017.- 156х.- ISBN 978-99978-17-29-7.


Хэрэглээний найруулга зүй бол утга зохиолын хэлний хэм хэмжээ, найруулах ур маягийг өдөр тутмын ярианы хэл, бичгийн хэрэглээнд ашиглах аргыг судалдаг ухаан бөгөөд энэ ном нь найруулга зүйн ухаанд суралцах арга зөвлөмжийг дасгал, жишээний хамт уншигч таны гарт хүргэж байна.

81.2М-5

Б-341

/НУН унш-4, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28122-28124



Ким Ки-Сонь., Бат-Ирээдүй Ж. **Монгол бичвэр унших бичиг**: Монгол хэлийг гадаад хэлээр үзэх оюутан суралцагч нарт зориулсан сурах бичиг / Хян. Х.Дэлгэрмаа, Ж.Ичинхорлоо.- УБ.: МУИС пресс, [2017].- 277х.- ISBN 978-99978-58-12-2.

Монгол хэлийг сонирхон судалж буй гадаад хүмүүст зориулсан энэ сурах бичигт Монгол улсын нийгэм, улс төрийн амьдрал, газар нутаг, байгаль, өв соёл, ёс заншил, түүхт хүмүүсийн намтар түүх, үлгэр домог хууч яриа зэрэг нийт 190 гаруй бичвэрийг оруулж, үүнээс эхний 60 шахам бичвэрт холбоотой шинэ үг, хэллэгийг англи хэлээр оруулж, хэл зүйн түгээмэл загварыг тухай бүрд нь хийж, мөн асуулт, сорилгуудыг хариуны хамт хийжээ.

81.2М-96

К-38

/НУН унш-3ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-19271-19272



Munkhbayer N., Nyamsuren B. **Learning English through literature.**- УБ.: Soyombo printing, 2017.- 170р.- ISBN 978-99962-4-655-5.



МУБИС-ийн НХУС-ийн Гадаад хэлний төвийн англи хэлний багш Н.Мөнхбаяр, Б.Нямсүрэн нар Монгол хэл, Уран зохиолын ангийн оюутнуудын мэргэжлийн англи хэл, тэдний бие дан сурах үйл ажиллагааг үр бүтээлтэй байлгах зорилгоор “Уран зохиолоор дамжуулан англи хэл сурах нь” гэсэн нэртэй, ХХ зууны Монголын шилдэг 16 богино өгүүллэгийг англи орчуулгын хамт багтаасан гарын авлага бичжээ. Эх зохиол бүрийг англи хэл дээр задалсан энэхүү гарын авлага нь цаг үеэ олсон, өнөөгийн оюутны хэрэгцээ шаардлагад нийцсэн, оюутнуудад мэргэжлийн чиглэлээр судалгаа шинжилгээ хийхэд нь тус дөхөм болсон бүтээл болжээ.

81.2Eng+83.3(1)

М-95

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21459-21461

### УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ



Мөнгөнхөлөг Б. **Хос дэвтэр=Уран зохионгуйн ертөнцөөр** / Ред. Я.Баатар.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 112х.- ISBN 978-999622454-6.

Энэ бүтээлд монголын уран зохиолын ноён оргил Д.Нацагдорж, Б.Явуухулан, Л.Түдэв, яруу найрагч Долгорын Нямаа, Данзангийн Нямаа, утга зохиол судлаач Д.Галбаатар нарын уран бүтээлийн гоо сайхны сэтгэлгээ, уран сэтгэмжийн онцлогийг судлаачийн зүгээс шинжлэн тэмдэглэжээ.

83.3(1)

М-812

/НУН унш-4, ГНОФ-3 /

ЭШФ Б-28116-28118

Бат Д. **Монгол уран зохиолын тухай тэмдэглэлүүд** / Ред. С.Байгалсайхан.- УБ.: Жиком Пресс, 2017.- 210х.- ISBN 978-99978-834-8-3.



БНХАУ-ын Баруун Хойтын Үндэсний Их сургуулийн Монгол судлалын багш доктор Даржаагийн Батаагийн сүүлийн 10-аад жилийн хугацаанд Монголын уран зохиолын тухай хийсэн судалгаа, ажиглалт, тэмдэглэлүүдийг нэгтгэн гаргаж байна. Энэхүү бүтээл нь 2017 онд эрдэмтэн Д.Батаагийн хэвлэн гаргаж буй БНХАУ-ын монгол хэлт оюутнуудад зориулсан Монголын яруу найраг, уран зохиолын тухай сурах бичгийн номын үндэс суурь болжээ. Мөн Монгол утга зохиолын мөн чанарын тухай, туурвилзүйн асуудлаар анх удаа Өвөрмонголын эрдэмтэн багш хөндлөнгөөс харж задлан шинжилж уран сайхны сэтгэлгээний гаргалгаа хийж байгаа юм.


83.3(1)1

Б-33

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28093-28094

**УРАН ЗОХИОЛ**



Аюурзана Г. **Судасны чимээ**: Роман / Ред. Л.Өлзийтөгс.- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 231х.- ISBN 978-99973-2-776-5.

"Судасны чимээ" романд Монгол үндэстний соёлын онцгой өв болсон уламжлалт бариа засал, эм эмнэлгийн сэдвийг орчин цагийн амьдралтай уялдуулж, хувь тавилан, учир шалтгаан, эрт эдүгээгийн сэтгэлгээний харилцан шүтэлцээ зэрэг ойлголт өнөөгийн хүний сэтгэлзүйд хэрхэн тусч буйг харуулжээ.


84(1)

А-967

/НУН унш-7ш, ГНОФ-8ш/

ЭШФ Б-28428-28430

Цэдэн-Иш Д. **Аян зам**: Бодол эргэцүүлэл / Хян. Б.Пүрэвдаш, Ц.Амартүвшин.- УБ., 2017.- 424х.- ISBN 978-99978-1-872-0.




Сэтгүүлч Донойн Цэдэн-Ишийн энэхүү ном нь түүний аян замын тэмдэглэлээс бүтжээ. Тэрээр Ази, Европ, Америк тив гээд дэлхийг тойрсон бөгөөд аливаа улс оронд зорчихдоо жуулчин маягаар явсангүй, сэтгүүлчийнхээ сонирхлоор аялах орныхоо түүх, соёлыг судалсан нь харагдаж байна. Мөн гадаадад яваа монголчуудын тухай ч өгүүлжээ. Ийнхүү агуулгын хувьд арвин баялаг, сэтгүүлчийн амьд хэлээр туурвисан бүтээлээ та бүхэнд өргөн барьж байна.

84(1)

Ц-941

/НУН унш-3ш/

ЭШФ Т-21359-21360



Аюурзана Г. **Хүүрнэл зохиолын товчоон**.- УБ.: Мөнхийн үсэг, 2014.- 266х.- ISBN 978-99973-2-895-3.

Зохиолч, яруу найрагч Г.Аюурзанын энэхүү номонд “Дурлалгүй ертөнцийн блюз” метароман, “Цасны роман” бичил тууж, “Хэвтрийн хүн” оп-роман, “Амь тавьж буй шувууны далавч” метароман гэсэн бичлэгийн хувьд тус тусдаа бие даасан зохиолууд нь багтжээ. Метароман хэмээгч нь орчин цагийн хүүрнэл зохиол дахь постмодерн чиг хандлагыг илэрхийлэгч жанр бөгөөд хамгийн товчоор тодорхойлбол, өнгө аясын хувьд ойролцоо өгүүллэгүүд нийлж нэгэн цогц романы санааг илтгэдэг. Тэдгээр өгүүллэгийг тус тусад нь уншиж ч болдог онцлогтой.

84(1)-44

А-967

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28431-28433

Бүрэнтөгс Э. **Дэлгэрхангай**: Роман / Ерөн. ред. С.Байгалсайхан.- УБ.: Жиком Пресс, 2017.- 454х.- ISBN 978-99978-1-800-3.



“Монгол туургатны сонгомол номын сан” төслийн хүрээнд Монгол туургатны уран зохиолын шилмэл бүтээлээс дээжлэн монгол хэлээр орчуулах, кирилл үсгээр буулган нэгэн цогц болгон хэвлэн нийтлэх, түгээх ажлыг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Үүний үр дүнд Өвөрмонголын орчин цагийн хүүрнэл зохиолын төлөөлөгч Э.Бүрэнтөгсийн алдарт “Дэлгэрхангай” романыг хэвлэн хүргэж байна. Энэхүү романаас хувь заяаны эрхээр олон газар тархан суурьшсан Монгол үндэстний сэтгэлгээний, хэлний, ахуйн ижил болон ялгаатай тал, түүхэн цаг үеийг хэлний өндөр түвшинд гаргасан нь ах дүүгээ улам сайн таних, мэдэх, ойлгоход чухал алхам болох юм.

84(1)-44

Б-87

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28119-2812



Оюунгэрэл Ц., Флот Жеффри Л. **Жаран цагаан хонь**: Роман: “Ногоон нүдэн лам” романы хоёрдугаар дэвтэр / Орч. ред. Ц.Оюунгэрэл.- УБ.: Сэлэнгэпресс, 2017.- 680х.- ISBN 978-99978-1-869-0.

Зохиогч Ц.Оюунгэрэл нь “Ногоон нүдэн лам” романыхаа үргэлжлэл болгон “Жаран цагаан хонь” романаа үнэн бодит амьдралаас сэдэвлэн туурвижээ. Тэрээр Монгол орныхоо тусгаар тогтнолыг бэхжүүлж өгсөн малчин ардынхаа хөдөлмөрч, эгнэшгүй гавьяаг хүндэтгэн, энэхүү номоо үе үеийн малчид, тэдгээрийн үр хүүхдүүдэд зориулав.

84(1)-44

О-634

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21424-21426

Өлзийтөгс Л. **Хотын үлгэрүүд**: Тууж, өгүүллэгүүд / Ред. Г.Аюурзана.- УБ.: Сэлэнгэпресс, 2013.- 334х.- ISBN 978-99962-1-887-3.



Зохиогч Л.Өлзийтөгс нь яруу найраг, хүүрнэл зохиолын төрлөөр уран бүтээлээ туурвидаг бөгөөд түүний яруу найргийн бүрэн түүвэр нь 2009 онд солонгос хэлнээ хэвлэгдэж байжээ. Түүний шүлэг, өгүүллэгүүдээс нь англи, орос, хятад, польш, румын зэрэг 8 орны хэлээр орчуулагдан гарчээ. Энэ удаад зохиогч "Хотын үлгэрүүд" нэртэй тууж, өгүүллэгүүдийн түүвэр номоо уншигч таньд өргөн барьж байна.

84(1)-44

Ө-741

/НУН унш-7ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28425-28427



Сумьяа Д. **Амармагийн ааль**.- УБ.: Жиком Пресс, 2017.- 232х.- ISBN 978-99978-60-23-1.

Яруу найрагч Доржпаламын Сумьяагийн энэхүү бүтээл нь хоёр хэсгээс бүрдсэн байна. Эхний хэсэгт түүний туурвисан өгүүллэг, тууж, кино

туужууд багтсан бол хоёр дахь хэсэгт голчлон нутаг усны түүх, аав ээж, эрхэм дотны хүмүүсийн тухай дурсамж, бодрол, тэмдэглэл, эссэ багтжээ.

84(1)-44

C-729

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28091-28092

Цэнджав Д. **Цэвдэг жаран**: Түүхэн урансайхны эсээ роман / Ерөн. ред. Д.Өлзийбаатар; Хян. А.Цэнд-Аюуш.- УБ.: Бэмби сан, 2017.- 690х.- ISBN 978-99978-1-637-5.



Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Д.Нацагдорж, С.Буяннэмэх, МЗЭ-ийн шагналт зохиолч, Д.Бодоогийн шагналт сэтгүүлч, нийтлэлч Долгорын Цэнджав түүхэн роман, тууж, өгүүллэгийн олон ном хэвлүүлсэн бөгөөд энэ удаад тэрээр гучаад оны улс төрийн зүтгэлтнүүдийн амьдрал, зөрчилт үйл явдал, их хэлмэгдүүлэлтийн талаар тусгасан түүхэн урансайхны эсээ “Цэвдэг жаран” хэмээх романаа уншигчиддаа хүргэж байна.

84(1)-44

Ц-956

/НУН унш-7ш, ГНОФ-10ш/

ЭШФ Б-28347-28349



Бат-Оргил Т. **Жигүүртнээс дээгүүр** / Ред. Р.Сарангэрэл.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 191х.- ISBN 978-99978-2-037-2.

Энэхүү номоор дамжуулан Төрболдын Бат-Оргил нь өөрөө аяыг нь зохиож, шүлгийг нь бичиж дуулсан дуунуудынхаа утгыг тайлж, бас үзэл бодлоо хуваалцжээ. Мөн дуунуудынхаа CD-г амьд хөгжмийн зэмсгээр тоглож хавсаргасан нь шинэлэг болж соёл урлагийн түүхэнд нэгэн сонирхолтой алхам болсон байна.


84(1)-5

Б-330

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28416-28417

Гамзатов Р. **Шүлэг, найраглал** / Орч. Д.Бор; Хян. Д.Нямаа.- УБ.: Хөх судар принтинг, 2017.- 224х.- ISBN 978-99978-0-167-8.



Яруу найрагч, орчуулагч, ХАА-н ухааны доктор Дарьзавын Бор сүүлийн жилүүдэд Зөвлөлтийн яруу найргаас орчуулж Р.Гамзатовын “Тогоруун цуваа”, А.С.Пушкины “Шүлгүүд”, С.А.Есениний “Амин хайртай Оросмину” зэрэг хэд хэдэн сонирхолтой номууд гаргаж уншигчдын хүртээл болгосон билээ. Энэ удаад Д.Бор Р.Гамзатовын шүлгээс нэмж орчуулан “Шүлэг, найраглал” нэртэйгээр хадмал орос эхтэй нь зэрэгцүүлэн та бүхний гарт хүргэж байна.

84(2Орос)-5

Г-20

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28085-28086



Ахматова А. **Би-та нарын дуу хоолой, халуун амисгаа** / Орч. С.Дондог; Ред. Х.Мэргэн, А.Шархүү, Ц.Цогзолмаа; Хян. Г.Адияа.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2018.- 346х.- (Миний яруу найргийн номын сан).- ISBN 978-99978-2-252-9.

С.Дондог энэ удаад Оросын яруу найрагч Анна Ахматовагийн яруу найргийн шүлгүүдээс сонгож түүвэрлэн оруулсан байна. Анна Ахматовагийн шүлэг, яруу найраг нь уран нарийн санааг товч тодорхой, оносон үг хэллэгээр илэрхийлдэг, хүний сэтгэлзүйн нарийн утсыг, тэр тусмаа бүсгүй хүний сэтгэлзүйн өвөрмөцийг давтагдашгүй нандинаар гаргадаг, нийгмийн асуудлыг бол учир шалтгаантай нь тод томруун үзүүлдэг онцлогтой юм.

84(2Орос)-5

А-902

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28452-28454

Вересаев В.В. **Эмчийн тэмдэглэл** / Орч. З.Мэндсайхан; Ред. Б.Нэргүй.- УБ.: Нэпко, 2017.- 209х.- ISBN 978-99962-66-68-3.



Оросын алдарт зохиолч, эмч В.В.Вересаевын "Эмчийн тэмдэглэл" зохиол нь эмчийн хөдөлмөр эрхэлсэн он жилүүд, авъяаслаг уран зохиолчийн авъяас билэг, өргөн мэдлэгийнх нь нэг үзүүлэлт юм. Зохиолч энэхүү тэмдэглэлдээ эмчийн бусдыг гэх нандин сайхан өгөөмөр нинжин сэтгэл, хүнийг бүхэлд нь авч үзэх төв үзэл, эмчийн хөдөлмөрийн нарийн нандин чанар, ухаарал цөхрөл тэргүүтнийг нүдэнд харагдаж, сэтгэлд хоногштол яруу тод нээн харуулсан байна.

84(2Орос)-44

В-313

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28449-28451



Шарлотта Б. **Жейн Эйр**: Роман: Боть-I, II / Орч. Б.Хулан, Ц.Сувд, Г.Энх-Амар; Хян. Б.Шүүдэрцэцэг, Д.Болдхуяг.- УБ.: Адмон принт, 2017.

Английн уран зохиолын романтизм, реалист чиглэлийн томоохон төлөөлөгч Шарлотта Бронтегийн "Жейн Эйр" зохиол нь нэгдүгээр биеэс өгүүлэх хэлбэрээр бичигдсэн зохиол юм. Зохиолын гол баатар Жейн Эйр охин нялхдаа эцэг эхээсээ өнчирсөн бөгөөд Жейний 10 наснаас эхлэн өрнөдөг. Шарлотта энэхүү романаараа зоримог шийдэмгий, хэзээ ч бусдын нөлөөнд авталгүй амьдралаа залж чаддаг ухаантай эмэгтэйн дүрийг гаргаснаараа хүчирхэг эмэгтэй баатрыг уран зохиолд төрүүлж чадсан юм.

84(4Англ)


Ш-310

Боть-I.- 2017.- 202х.- ISBN 978-99978-1-829-4. /НУН унш-5ш, ГНОФ-5ш/  
ЭШФ Б-28350-28352

Боть-II.- 2017.- 219х.- ISBN 978-99978-1-830-0. /НУН унш-5ш, ГНОФ-5ш/  
ЭШФ Б-28353-28355



Бөрнс Р. **Яруу найраг** / Орч. С.Дондог; Хян. Б.Пүүшил, Ц.Сүхбаатар, Г.Адияа.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2018.- 340х.- (Миний яруу найргийн номын сан).- ISBN 978-99929-3-084-7.



Шотландын ард түмний алдарт хүү, аугаа яруу найрагч Бөрнс Робертын туурвисан шүлэг, дууль, улс төрийн яруу найраг, хошигнол, шүлэглэсэн тууж зэргийг МУИС-ийн Хүндэт доктор, Химийн салбарын багш, профессор С.Дондог орчуулан уншигч та бүхэндээ хүргэж байна.

84(4ИхБр)-5

Б-669

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28437-28439



Вийон Ф. **Яруу найраг** / Орч. С.Дондог; Хян. Ц.Сүхбаатар, Т.Төмөрхүлэг.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2018.- 170х.- (Миний яруу найргийн номын сан).- ISBN 978-99929-3-002-0.

Францын түүхнээ жинхэнэ франц яруу найрагч хэмээн үзэгддэг, тэрс үзэлтэн алдартай яруу найрагч Франсуа Вийоны дөрвөн мөрт шүлгүүдийг С.Дондогийн орчуулгаар та бүхэнд хүргэж байна. Энэхүү орчуулгын ном нь франц хэл, утга зохиолыг судлагч оюутан, судлаачдад сургалт судалгааны чухал хэрэглэгдэхүүн болох юм.

84(4Фр)-5

В-42

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28434-28436

Сартр Жан-Поль. **Үг**: Намтарчилсан тууж / Орч. Г.Аюурзана.- 2 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2015.- 199х.- ISBN 978-99929-0-822-X.



Францын зохиолч, философич Жан-Поль Сартр (1905-1980) бол өнөө цагийн иргэншил төлөвшихөд гойд үүрэг гүйцэтгэсэн суут сэтгэгч билээ. Түүний энэ ном 1964 оны Нобелийн утга зохиолын шагналыг хүртсэн юм. Дурсамж намтрын номуудаас хамгийн оюунлаг нь хэмээн тооцогдсоор ирсэн "Үг" тууж нь зохиолч хүний дотоод ертөнцийн төлөвшил, үгийн урлагийн мөн чанарын тухай хамгийн гоц туурвил төдийгүй, жинхэнэ уншигчийн зиндааг сорьдог буурьтай утга зохиолын нэгэн оргил билээ.

84(4Фр)-44

С-362

/НУН унш-7ш, ГНОФ-8ш/

ЭШФ Б-28461-28463



Шиси Ш. **Чонын мөрөөдөл** / Орч. Б.Гэрлээ.- УБ.: Нэпко, 2017.- 194х.- ISBN 978-99978-51-17-8.

Хятадын хүүхдийн зохиолч Шэнь Шиси ан амьтны тухай зохиол бүтээлээрээ алдартай юм. Энэ номд Зылань хэмээх зоригтой өлөгчний амьдралын төлөөх тэмцлийн тухай өгүүлдэг бөгөөд тэрээр бэлтрэгнүүдийнхээ нэгийг сүргийн ахлагч болгохын төлөө амь хайргүй зүтгэдэг. Чонын ёсоор амьдарна гэдэг хэцүү боловч хүсэл мөрөөдлийнхөө

төлөө зүтгэнэ гэдэг түүнээс ч бэрх. Зылань Гамаарын хөндийг эзэгнэх сүргийн ахлагчийг төрүүлэхийн тулд хүнд хүчир амьдрал туулахдаа ойр дотныхныгоо алдаж энэ биеэ золин эцсийн дүндээ амь алдана.

84(5Хят)-44

Ш-692

/НУН унш-4ш, ГНОФ-3ш/

ЭШФ Б-28458-28460

Рампо Э. **Сүүдэрт гэтэх албин** / Орч. Д.Дашмөнх; Ред. Ц.Дэлгэрмаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2017.- 200х.- ISBN 978-99978-1-503-3.




Японы адал явдалт зохиолч Эдогава Рампогийн уран бүтээлийн өв хорь орчим боть болох бөгөөд үүнээс "Хүн сандал", "Толин там", "Зурагтай аялагч", "Улаан тасалгаа" зэрэг олон өгүүллэгүүд, "Сүүдэрт гэтэх албин", "Хар гүрвэл", "Сохор мангас" туужууд нь дэлхийн олон хэлээр орчуулагдсан алдартай бүтээлүүд юм. Түүний энэхүү түүвэрт "Сүүдэрт гэтэх албин", "Авгалдай", "Хоёр рашаанчин эр" бүтээлүүд нь багтжээ.

84(5Яп)-44

P-21

/НУН унш-3ш/

ЭШФ Б-28083-28084



Болд Э. **Их талын цаад тал**: Яруу найргийн түүвэр / Ред. А.Эрдэнэ-Очир.- УБ.: Мөнхийн үсэг, 2016.- 80х.- ISBN 978-99973-53-82-5.

ӨМӨЗО-ы яруу найрагч Эрэнцэндоржийн Болд нь 2001 онд "Яруу найраг-Зүрхэн хөдөлгөөний зураг", 2004 онд хятад хэлээр "Далд тэнгэрийн өчил", 2012 онд "Хөх нулимстай тэнгэр" яруу найргийн түүвэр хэвлүүлсэн бөгөөд энэ удаад "Их талын цаад тал" яруу найргийн түүврээ өргөн барьж байна. Тэрээр "Гилгүүн-Уянга-2007" яруу найргийн наадмын тэргүүн байрын

Алтан-Од шагналт уран бүтээлч юм.

84(545)-5

Б-547

ЭШФ Б-28477

### УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ

Бадраа Ж. **Монгол ардын урлаг судлал**: Боть-1: Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган / Эрхл. Б.Цэцэнцолмон.- УБ., 2017.- 294х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN 978-99978-58-41-2.



Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, ардын урлаг судлаач, яруу найрагч Ж.Бадраагийн ардын урлаг судлал, соёл, урлаг судлал, угсаатны хөгжим судлал, монгол хэлний найруулга зүй, утга зохиолын холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээлийг цуврал гурван боть болгон хэвлүүлж байгаа билээ. "Монгол ардын урлаг судлал" хэмээх нэгдүгээр ботид Ж.Бадраагийн бичсэн "Монгол ардын хөгжим" нэгэн сэдэвт бүтээл болон ардын урлаг судлалын онол, аргазүй,

орчин үеийн соёл, урлаг судлалын эрдэм шинжилгээ, танин мэдэхүйн бүтээлээс түүвэрлэн оруулжээ.

85

Б-159

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21337-21341



Бадраа Ж. **Их дуучны яриа**: Боть-2: Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган / Эрхл. Н.Жанцанноров.- УБ., 2017.- 216х.- (Монгол Улсын Их сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN 978-99978-58-41-2.

Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, ардын урлаг судлаач, яруу найрагч Ж.Бадраагийн ардын урлаг судлал, соёл, урлаг судлал, угсаатны хөгжим судлал, монгол хэлний найруулга зүй, утга зохиолын холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээлийг цуврал гурван боть болгон хэвлүүлж байгаа билээ. Энэхүү хоёрдугаар ботид гавьяат дуучин Жигзавын Дорждагвын товч намтарыг өгүүлээд, уртын дууны тухай болон дуулах арга барилын талаар дуучид хөгжимчидтэй яриалцсан яриаг хуурцагнаас буулган хэвлүүлжээ.

85

Б-159

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21342-21346

Бадраа Ж. **Судлах, сургахын арга ухаан**: Боть-3: Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган / Эрхл. Д.Цэдэв, Ч.Дагвадорж.- УБ., 2017.- 296х.- (Монгол Улсын Их сургууль. Монгол Судлалын Хүрээлэн).- ISBN 978-99978-58-41-2.



Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, ардын урлаг судлаач, яруу найрагч Ж.Бадраагийн ардын урлаг судлал, соёл, урлаг судлал, угсаатны хөгжим судлал, монгол хэлний найруулга зүй, утга зохиолын холбогдолтой эрдэм шинжилгээний бүтээлийг цуврал гурван боть болгон хэвлүүлж байгаа билээ. Энэ удаагийн гуравдугаар ботид Ж.Бадраагийн “Монгол хэлний найруулга зүй”, “Нэр томьёо судлал”, “Дорно дахины утга соёл” гэсэн судалгаа, сурталчилгааны өгүүлэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг оруулав.

85

Б-159

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Т-21347-21351



Даваапил П. **Урлаг судлалд** / Ред. Д.Даваасүрэн, Ш.Ариунаа.- УБ.: МУИС Пресс, 2018.- 256х.- ISBN 978-99978-58-43-6.

МУИС-ийн Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш П.Даваапил нь хөгжим судлал, дүрслэх урлаг судлал, соёл урлагийн бодлого судлал, гоо зүй урлагийн боловсрол судлалын талаарх өнөө цагийн тулгамдсан асуудал, өнгөрсөн үеийн эрэл айгуулын мөрөөр хийсэн өгүүллүүдээ та бүхэнд хүргэж байна. Эдгээр судалгааны ажил, илтгэл өгүүллүүддээ соёл, урлагийн бодлого, урлагийн боловсролын үнэ цэнэ, үндэс суурийг зөв зохистой зохион

байгуулах, тогтвортой явуулах шаардлагатай байгааг дурдсан нь их, дээд сургуулийн оюутнууд, Монголын соёл урлагийг сонирхогч хэн бүхэнд хэрэгтэй, өгөөжтэй бүтээл болжээ.

85

Д-121

/НУН унш-5ш, ГНОФ-3ш/

ЭШФ Т-21435-21439

**Ойн унанги болон хатсан мод, хожуул, мөчир гишүү, навч боргоцой ашиглан экологид ээлтэй бүтээгдэхүүн урлах гарын авлага:** Байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд зориулав.- УБ., 2017.- 128х.



Тус гарын авлагыг байгаль хамгаалах нөхөрлөлүүд, тэр дундаа ойн санг гэрээгээр хариуцан хамгаалдаг ойн нөхөрлөлүүдэд зориулжээ. Энэхүү номоор дамжуулан ойд хандах хандлага, ойг ойлгож харах, ойтой харьцах байдлыг өөрчлөхийг зорьж, үүний зэрэгцээ ойн дагалдах түүхий эдийг ашиглан бүтээгдэхүүн урлах арга, технологитой танилцуулахыг зорьжээ.

85.125+43

О-239

/БУН унш-3ш/

ЭШФ Б-28260-28261

## **ШАШИН. ШИД ТАРНИ. ЧӨЛӨӨТ СЭТГЭЛГЭЭ.ГҮН УХААН**



**Монголын бурханы шашин дахь Дээрхийн гэгээн Богд Жавзандамба хутагтын институт:** Өнгөрсөн, эдүгээ ба ирээдүй: Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал / Эрхл. О.Батсайхан.- УБ.: Бит пресс, 2018.- 128х.- ISBN 978-99978-2-264-2.


Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 106 жилийн ойд зориулан Монголын бурхан шашинтны төв, Гандантэгчэнлин хийд, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн, Номын гурван хүрдэн сан ТББ хамтран “Монголын бурханы шашин дахь Дээрхийн гэгээн Богд Жавзандамба хутагтын институт: Өнгөрсөн, эдүгээ ба ирээдүй” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулжээ. Энэхүү номд тус хуралд гадаад дотоодын эрдэмтэн, багш, лам хуврагууд оролцсон бөгөөд тэдгээрийн хуралд тавьсан илтгэлүүдийг эхмэтгэн оруулав.

86.2(1)

М-695

ЭШФ Б-28476

**Монгол Хатдын Онгон түүхийн гялбаа** / Хян. Д.Цэнд-Аюуш, Л.Адъяамаа, Л.Дуламсүрэн ба бус.- УБ., 2018.- 798х.- ISBN 978-99962-4-898-6.



Энэхүү судар нь Онгод хэмээх сүнснүүдийн ярианаас бүтжээ. Тус судрын бүлэг тус бүрт төлөөлөл болсон хатад, гүнж нарын амин төрх байсан Онгодууд улаач үрстэй уулзан өөрсдийн туулсан түүхийн үйл явцыг тухайн үеийнхээ нийгэм, улс төр, ард түмний амьдралыг ярьж, асуултуудад

хариулсныг эмхэтгэжээ.

86.3+63.3(1)

М-692

ЭШФ Т-21514-21517



**Өгүүлэх ухаан:** Эрт улбаагаас өвлөгдсөн ухааныг энэ цагийн хүмүн бүрт зориулав / Эмхт. Л.Адьяамаа, Б.Мөнхгэрэл, Г.Мядагмаа ба бус.- УБ.: Бит пресс, 2018.- 532х.- ISBN 978-99978-53-37-0.

“Өгүүлэх ухаан” хэмээх энэхүү номд Онгодын сэтгэмжээр, өртөөч улаачдын харилцан хөөрөлдөөн хэлбэрээр орчин цагийн хүмүүст ойртуулан ойлгуулах зорилгоор ярих хийгээд өгүүлэхийн ялгаанаас эхлээд үгийн шид, хэл сэтгэхүйн онцлог, ойлголцол итгэлцлийн учиг, зөн билиг, итгэл бишрэл, хүмүүний сэтгэл зүй, нийгэмийн харилцаа, зохион байгуулалт, удирдах удирдуулах ёсон, уран сайхны сэтгэмж, урлаг соёл, хөгжил, дэвшлийн мөн чанар, утга агуулгын тухай олон сэдвийг хөндөж сонирхолтойгоор өгүүлжээ.

86.3+83.7

Ө-707

ЭШФ Б-28481-28484

Бум-Очир Д. **Монгол бөөгийн зан үйл:** Аман яруу найргийн төрөл зүйлс.- 2 дахь хэвл.- УБ.: МУИС пресс, 2017.- 196х.- ISBN 978-99978-58-24-5.

Энэхүү бүтээлийн эхний хэсэгт Монгол бөөгийн амьд зан үйл, ёслол хүндэтгэлийн баримтыг үндэс болгон бөөллөгийн үед тохиолдох нэгэн цул мэт үргэлжлэх дуудлагыг төрөл зүйлчлэн ангилж, ялгаа салгааг нь гаргаж учир зүйд нь нийцүүлэн тайлбарлажээ. Харин дараах хэсэгт зан үйл хэмээгч нь чухам юу болох тухай Евро-Америкийн эрдэмтдийн сөргөлцсөн онол саналыг Монгол бөөгийн зан үйлийн жишээгээр шинжлэн үзсэн бөгөөд уншигч та өнөөгийн манай нийгэмд хүчтэй сэргэж байгаа бөө болоод бөөгийн арга засал, бөөллөгийн үеийн хэл хэлмэр нь чухам юу өгүүлдгийг, тэр нь зан үйлтэй хэрхэн холбогдохыг мэдэж авах болно.

86.3(1)

Б-750

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28420-28424



Лесов А.Ф., Тахо-Годи А.А. **Платон** / Орч. А.Энхбаатар; Ред. Э.Энхцолмон, Б.Мөнхнасан.- УБ.: Адмон принт, 2016.- 151х.- ISBN 978-99973-0-918-1.

М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын их сургуулийн доктор, профессор А.Ф.Лосев, А.А.Тахо-Годи нарын бичсэн эртний грекийн суут философич, объектив идеализмын эцэг хэмээн алдаршсан, номч мэргэн Платоны (МЭӨ 427-347) тухай энэ номыг философи, түүх, улс төр сонирхогч оюутан залуусынхаа философи сэтгэлгээний хөгжилд зориулан орчуулан хүргэж байна. Энэхүү орчуулгандаа анхны бичвэрийг хэвээр хадгалахыг эрхэмлэжээ.

87.3

Л-78

/НУН унш-5ш, ГНОФ-5ш/

ЭШФ Б-28391-28393



## СЭТГЭЛ СУДЛАЛ

**Сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг туслалцааны онол практикийн тулгамдсан асуудлууд:** Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл / Эмхт. М.Нарантуяа.- УБ.: Оргил пресс, 2018.- 112х.- (МУИС. Шинжлэх Ухааны Сургууль. Нийгмийн Ухааны Сургууль. Боловсрол Сэтгэл Судлалын Тэнхим).



Энэхүү бүтээлд сэтгэл зүйн зөвлөгөөний онол, практикийн өнөөгийн байдал тулгамдсан асуудал, гарц шийдлийн талаар салбарын 30 гаруй эрдэмтэн судлаачдын хэлэлцүүлсэн 18 илтгэлийг эмхэтгэжээ.

88.5

C-974

ЭШФ Т-21000-21002



**Канфилд Ж. Амжилтын зарчмууд:** Тэргүүн дэвтэр: Өнөөгийн нөхцөлөө өөрчлөн мөрөөдөлдөө хүрэх аргачлал / Орч. Д.Баясалжаргал, Д.Болор-Эрдэнэ, Ж.Баянжаргал, Э.Сугармаа; Хян. Д.Алтанцэцэг, Г.Эрдэмаа, Д.Батнасан, Д.Доржсайхан.- 2 дахь хэвл. УБ.: Адмон принт, [2018].- 368х.- ISBN 978-99978-0-394-8.

Бодит туршлагад тулгуурласан, хүмүүст урам зориг хайрлах Жак Канфилдийн энэхүү “Амжилтын зарчмууд” номын орчуулгыг хоёр дэвтэр болгон та бүхэнд хүргэж байна. Тэргүүн дэвтэрт амжилтанд хүрэхийн тулд эзэмших 24 үндсэн зарчим болон амжилтын төлөө өөрийгөө хэрхэн өөрчлөх талаар өгүүлнэ.

88.52

K-198

/НУН унш-4ш/

ЭШФ Т-21418-21420

**Мэнсон М. Тоомжиргүй амьдрах бяцхан урлаг:** Сайхан амьдралд хүрэх эсрэг зам / Орч. Р.Нармандах, Б.Алтжин, Ц.Наянжин; Ред. Э.Түвшинбаяр.- 2 дахь хэвл.- УБ.: Монсудар, 2017.- 224х.- ISBN 978-99973-1-479-6.



Энэ ном танд хэрхэн бий болгох, бүтээхийг биш, харин хэрхэн алдах, тавьж явуулахад сургана. Уг номыг уншсанаар та өөрийн амьдралдаа дахин бүртгэл явуулж, хамгийн чухлаасаа бусдыг арчин хаях болно. Энэхүү бүтээл танд нүдээ аниад гэдрэг унасан ч та зүгээр байх болно гэдэгт итгэхийг, харьцангуй бага зүйлд ач холбогдол өгөхийг, танд хичээхгүй байхыг заана.

88.52

M-967

/НУН унш-4ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-28455-28457



Оливия Ф.К. **Харизм**: Бусдын хүндэтгэлийг хүлээж, өөртөө татах цоо шинэ шинжлэх ухаан / Орч. Б.Номин; Хян. Ц.Бямбадорж.- УБ., 2017.- 272х.- ISBN 978-99978-909-5-5.

“Харизм” номыг уншсанаар та бусдад нөлөөлөх чадвараа нэмэгдүүлж, хүмүүсийн итгэлийг хүлээж, тэдэнд урам зориг өгөх болно. Оливия Фокс Кабейн нь дэлхийд алдартай олон хүнийг харизмтай болоход нь тусалсан мэргэжлийн хүн юм. Тэрээр харизмын эх үндсийг судалж, бусдыг татах удвдсын нууцыг энэхүү номоороо дэлгэж байна. Харизмаа сайжруулах нь хувийн зан чанараа өөрчлөх гэсэн үг биш бөгөөд бусдыг өөртөө татах чадвараа нэмэгдүүлэх тухай ойлголт ажээ.

88.52

О-284

/НУН унш-5ш, ГНОФ-4ш/

ЭШФ Б-28464-28466

### ГАДААД ХЭЛ ДЭЭРХ НОМ

Advanced research in Materials science: The 6<sup>th</sup> international conference on materials science (6<sup>th</sup> ICMS 2017) / Edit. J.Davaasambuu, J.Temuujin.- UB., 2018.- 152p.- ISBN 978-3-0357-1253-7.


This volume contains peer-reviewed papers presented at the 6<sup>th</sup> International Conference on Materials Science (ICMS2017) the Conference was organized by the Mongolian Physical Society. After a critical screening and review, 20 papers were selected for publication in this volume.



30.3

A-20

ГФ-19426-19430



**Comparing Modern Empires**: Imperial Rule and Decolonization in the Changing World Order / Edit. U.Tomohiko.- Japan.: SRC., 2018.- 235p.- ISBN 978-4-938637-93-4.

This volume is a collection of selected papers presented at the international symposium "Comparing modern empires: Imperial Rule and Decolonization in the Changing World Order", held at the slavic research center of hokkaido university on january 19-20, 2012. Group 4 studied history. China, India and

Russia are sometimes called new or rising powers, but they have a rich history, even more ancient than many other powers.

63.3(0)

C-73

ГФ-19424

Undrakh D., Ulziisaikhan Ch. **Mongolia: Changing political reality** / Edit. D.Tuul.- UB.: Arvai Barkhan, 2018.- 72p.- ISBN 978-99978-2-732-6.




This time, we have decided to publish a collection of our scholarly articles on various socio-political issues of Mongolia in chronological order. The wide range of topic shows a shift of authors' research areas in connection with socio-political demand of the time in reliance with the influence of deepening clash of interests in Mongolian politics.

66.1(1)

U-51

ГФ 19452-19456



**Trans-Continental Neighbours: Vol-I: A Documentary History of Mongolia-UK Relations** = Тив дамнасан хөршүүд: Тэргүүн дэвтэр: Монгол-Британий харилцааны баримтат түүх / Edit. B.Altangerel, Uradyn E.Bulag, S.Chuluun, D.Shurkhuu.- UB., 2013.- 250p.


The United Kingdom of Great Britain and Northern Ireland was the first Western country to recognize Mongolia. The establishment of diplomatic relations on 23 January 1963 provided the opportunity to develop the historical bond between our two countries to a new level. Today our bilateral relations are successfully developing in many fields based on such common values as plurality of opinion, human rights, freedom, transparency, the rule of law, freedom of press and the market economy.

66.4(1)

T-82

/ОУХНУС-3ш/

**Trans-Continental Neighbours: Vol-II: A History of Mongolia-UK Relations** = Тив дамнасан хөршүүд: Дэд дэвтэр: Монгол-Британий харилцааны баримтат түүх / Edit. B.Altangerel, Uradyn E.Bulag, S.Chuluun, D.Shurkhuu.- UB.: Munkhiin useg, 2013.- 271p.




This second volume of Trans-Continental Neighbours, which contains memoirs of those distinguished people who were personally in the important historical developments, as well as the analysis, ideas, prospects and visions of prominent scholars, will certainly be an invaluable source for researchers, foreign service officials and future generation seeking information on Mongolia-UK relations, its past, present and future.

66.4(1)

T-82

/ОУХНУС-2ш/



Undrakh D. **English handbook of Politics: This is an English handbook for students studying politics at universities and colleges** = Англи хэлний гарын авлага: Улстөр судлалын мэргэжлээр их, дээд сургууль, коллежид суралцагчдад зориулав / Edit. Yo.Dovchin.- UB.: Erdenezul, 2010.- 274p.- ISBN 978-99962-823-5-5.


This is an English handbook for students studying politics at universities and colleges. The basics of the book focus on students' reading comprehension, proficiency in foreign languages, and skills development, also includes grammar test exercises, puzzles, games, and tests.

81.2Eng+66

U-51

ГФ 19457-19464

Tolstoy L. **War and Peace** / Translated by. Louise, A.Maude.- Great Britain.: Wordsworth classics, 2001.- 964p.- ISBN 1-85326-062-2.



War and Peace is a vast epic centred on Napoleon's war with Russia. While it expresses Tolstoy's view that history is an inexorable process which man cannot influence, he peoples his great novel with a cast of over five hundred characters. Three of these, the artless and delightful Natasha Rostov, the world-weary Prince Andrew Bolkonsky and the idealistic Pierre Bezukhov illustrate Tolstoy's philosophy in this novel of unquestioned mastery. This translation is the one which received Tolstoy's approval.

84(2)-44

T-71

ГФ-19425